

АЛСЫН ХАРАА
2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ХҮНИЙ ХӨГЖИЛ

2

МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН
БОДЛОГО
ХҮНИЙ ХӨГЖИЛ



蒙古人民共和国
蒙古国

АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО



ХҮНИЙ ХӨГЖИЛ

2

Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн, нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.



ХҮНИЙ ХӨГЖИЛ

Ерөнхий редактор:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Баянгэрэлийн БАТБААТАР

Редакцын баг:

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН
Сундуйн СОДБААТАР
Өлзийбүрэнгийн ЖАМЬЯН
Цэдэнбалын ЭНХЦЭЦЭГ

Зөвлөх:

Аюушийн АРИУНЗАЯА
Лхагвын ЦЭДЭВСҮРЭН
Жамцын НАРАНТУЯА
Юрагийн АЛТАНТУЯА
Цогтсайханы БОЛОРМАА
Пүрэвийн ЛХАГВАСҮРЭН
Дондогдуламын ТҮНГАЛАГ
Дуламсүрэнгийн СҮРЭНЧИМЭГ

Туслан гүйцэтгэсэн:

Батцэнгэлийн ҮҮРЦАЙХ
Галбадрахын БИЛГҮҮН

Дизайнер:

Нямжавын БЯМБАЦОГТ
Жаргалсайханы МӨНХСАЙХАН

Гэрэл зураг:

МРА.МН
Жамбалын БАТБААТАР /Баку/
Хишигтогтохын ТҮШИГ

Хавтасны зураг:

Батбаатарын ЦОЛМОНБАЯР

Улаанбаатар хот 2022 он

Copyright © ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан болно. Бүтээлийг ашигийн бус зорилгоор олон нийтэд түгээх, хуваалцах, ашиглах, хэрэглэх эрхтэй бөгөөд гагцхүү эх сурвалжийг дурдана уу.

Хэвлэлийн эхийг Нэпко хэвлэлийн газарт бэлтгэж,
"Мөнхийн үсэг" ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN: 978-9919-511-63-0



ГАРЧИГ


| | |
|------------------------------|----|
| ХҮНЭЭ ДЭЭДЭЛСЭН ХҮНИЙ ХӨГЖИЛ | 8 |
| БОЛОВСРОЛ | 12 |
| ЭРҮҮЛ МЭНД | 22 |
| ГЭР БҮЛ | 30 |
| ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦ | 36 |
| ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН | 44 |
| ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ | 52 |
| МОНГОЛ ХҮНИЙ УДМЫН САН | 58 |

ХҮНИЙ ХӨГЖИЛ

Монгол Улс Үндсэн хуульдаа хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулахыг эрхэм зорилго болгосон. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн нэг чухал хэмжээс нь хүний хөгжил юм. Хүний хөгжлийн түвшнийг тооцох аргачлалд хөгжлийг дан ганц эдийн засгийн өсөлтөөр хэмжих нь учир дутагдалтай гэж үздэг ба илүү өргөн хүрээний үзүүлэлт болох тухайн улсын иргэдийн амьдралын чанар, сайн сайхан амьдралд хүрэх боломж, чадавх, эрх чөлөөний үзүүлэлтийг харгалzan хүний хөгжлийн түвшнийг тодорхойлдог. Олон улсад хүний хөгжлийг дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн гэсэн нэгдсэн үзүүлэлтээр хэмжиж байна.

Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлт болон орлогын тэгш байдлыг хангах нь дундаж давхаргыг тэлэхэд чухал нөлөөтэй бөгөөд ингэснээр ард иргэд чинээлэг, хангалиун амьдрах баталгаа болдог. Хүний хөгжлийн үндсэн хэмжүүр чанартай амьдрал гэж үзэх хандлага сүүлийн үед олон улсын эрдэмтдийн дунд давамгайлж, анхаарал татсан судлагдахуун болсон. Чанартай амьдралын үзүүлэлтэд хүн эрүүл байж, өөрийн авьяас чадвар, чадамжаа нээн илрүүлэх, түүнийгээ хөгжүүлэх, үр шимиийг нь хүртэх боломж, нөхцөлийг бий болгох явдал голлож байна. Хүний хөгжлийн суурь болох эрүүл мэнд, боловсролыг чанартай, хүртээмжтэй хүргэж, сайн сайхан амьдралын баталгааг хангаснаар иргэдийн хувьд амьдралын зохистой түвшинд хүрч, мөн нийгэмдээ бүтээлчээр оролцох боломж нээгддэг учиртай.

Иймээс дээрх хүчин зүйлсэд үндэслэн дүгнэвэл улс орны засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол цөм, хөдөлгөгч хүч нь хүний хөгжил билээ.



ХҮНИЙ ХӨГЖИЛ

ХҮНЭЭ ДЭЭДЭЛСЭН ХҮНИЙ ХӨГЖИЛ

Хүний хөгжлийг тухайн улсын хүн амын эрүүл мэндийг илтгэх дундаж наслалт, боловсролын үзүүлэлт, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр тооцох аргачлал нь хүний зохистой хөгжлийн үндсэн үзүүлэлт болж байна. Энэ үзүүлэлт эдийн засгийн хөгжил иргэн бүрд жигд хүрч байгаа эсэхийг төдийгүй бүх нийтээр амьдралын чанар дээшилж байгааг ч илтгэн харуулдаг.

ХҮНЭЭ ДЭЭДЛЭХҮЙ

Улс орнуудын хөгжлийг дан ганц эдийн засгийн үзүүлэлтүүдэд тулгуурлан тодорхойлох нь учир дутагдалтай бөгөөд хөгжлийн гол цөм нь нийгэм, эдийн засагт өөрчлөлт хийгч, түүнд оролцогч болсон ХҮН юм. Хүний төлөө, хүн төвтэй, хүмүүсийн оролцоотой хөгжил л жам ёсны байх боломжтой. Үүний тулд хүн нь эрүүл саруул байж, урт наслан, эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахуйц бүтээлч, чадварлаг байх нь хөгжлийн үндсэн шалгуур юм.

Хурдацтай хөгжиж буй дэлхийн улс орнууд хөгжлийн бодлогынхоо гол цөмд эдийн засаг байсныг халж, хүний хөгжлийг чухалчлах нь зохистой хэмээх үзэл хандлагыг баримтлах болжээ.

Манай улс дэлхийн улс орнуудтай харьцуулахад, хүн амын насны бүтцийн хувьд идэрших хандлага бүхий хүн ам зүйн цонх үе нээлттэй улс орны эгнээнд багтаж байна.

Үндэсний Статистикийн Хорооноос хийсэн хэтийн тооцоогоор Монгол Улсын хүн амын тоо 2050 он гэхэд 5.2 саяд хүрэх бөгөөд хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 1.8 хувьд хүрнэ. Хэтийн тооцооны дүнгээр манай улсын нийт хүн амд 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувийн жин 2020 онд 31.7 байсан бол 2050 онд 27.4 болох төлөвтэй байна.

Манай улсын нийт хүн амд 65, түүнээс дээш насныхны эзлэх хувийн жин 2020 онд 4.2 хувь байсан бол энэ үзүүлэлт 2050 онд



Зураг 1. Хүний хөгжлийн үзүүлэлт тооцох аргачлал



Эх сурвалж: Нэгдсэн Үндэстний Байгууллагын
Хөгжлийн Хөтөлбөр, 2022

12.0 хувь болж 3 дахин нэмэгдэхээр тооцоо гарчээ. Нөгөө талаас 65, түүнээс дээш настай хүн амын бүх хүн амд эзлэх хувь 10-аас их бол насны бүтцийн хувьд “Хөгшин” бүтээгдэй, 5 хувиас бага бол “залуу” насны бүтээгдэй гэж үздэг. Иймээс 2050 он гэхэд манай улс хүн ам насны бүтцийн хувьд насжих хандлагад шилжих төлөвийг илтгэж байна.

Хүний хөгжлийн үзүүлэлт нь хүний хөгжлийн гол хэмжүүрүүд болох урт удаан, эрүүл амьдрах, мэдлэгтэй байх, зохистой амьжиргааны түвшинд хүрэх дундаж амжилтын хураангуй хэмжүүр юм. Хүний хөгжлийн үзүүлэлт нь гурван хэмжээс бүрийн нормчлогдсон индексүүдийн геометрийн дундаж юм.

Эрүүл мэндийн хэмжигдэхүүнийг төрөх үеийн дундаж наслалтаар, боловсролын хэмжигдэхүүнийг 25 ба түүнээс дээш насны насанд хүрэгчдийн сургуульд сурсан жилээр, сургуульд орох насны хүүхдийн хүлээгдэж буй суралж жилээр үнэлдэг. Амьжиргааны түвшнийг нэг хүнд ногдох үндэсний нийт орлогоор хэмждэг.

Хүний хөгжлийн үзүүлэлт нь хүний хөгжилд хамаарах зүйлийн зөвхөн нэг хэсгийг хялбарчилж, тусгасан болно. Энэ нь тэгш бус байдал, ядуурал, хүний аюулгүй байдал, эрх мэдлийг нэмэгдүүлэх зэргийг тусгадаггүй байна.

Хүн амын өсөлтийн тогтвортой байдлыг хангах, төрөлтийн түвшнийг эргэн нөхөгдөх түвшнээс дээш байлгаснаар насжилтад бэлтгэхээс гадна хүн амын насны зохистой бүтцийг тодорхой


Дэлхий нийтийн хэмжээнд хүний хөгжлийг тодорхойлоходоо иргэдийнхээ амьдралын чанарт шийдвэрлэх нөлөөтэй хүчин зүйлс болох эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны түвшин гэсэн гурван үзүүлэлтийг харгалzan авч үздэг.

хугацаанд хадгалах ба энэхүү нөхцөлийг бүрдүүлэхийн тулд боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээг төрөөс санхүүжүүлж, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлага бидний өмнө тулж иржээ.

Монголын хүүхэд, залуучууд суурь шинжлэх ухааны олон улсын олимпиадуудад ч өндөр амжилт үзүүлж, мэдээлэл, технологийн том компаниудад амжилттай ажиллаж, шинэ нээлт, бүтээлүүд хийж байна. Энэ нь Монголчууд бид уул уурхайд тулгуурласан эдийн засгаас оюуны мэдлэгт тулгуурласан эдийн засаг руу шилжих нөөц, боломжтойг илтгэж байна.

Дэлхийн шилдэг их, дээд сургуулиуд, олон улсын боловсролын чанарын үнэлгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, сургалтын чанарыг дээшлүүлэх, суралцагчдын тоог нэмэгдүүлэх

Зураг 2. Хүн амын нас, хүйсийн суварга






замаар дэлхийд өрсөлдөх чадвартай, оюунлаг, бүтээгч, мэдлэгт суурилсан эдийн засагт шаардагдах өндөр ур чадвар бүхий мэргэжилтнүүдийг бэлтгэх хэрэгцээ нэгэнт үүсжээ.

Монгол орны хувьд дэвшилтэт технологи, техникийг түлхүү ашиглаж, тоон технологийн ололтыг нэвтрүүлэх замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна гэдгийг даяаршил, технологийн хувьсгал бидэнд харуулж байна.

Иймд Монгол Улс дэлхийн бусад улс орны нэгэн адил хүнээ дээдэлсэн хөгжлийн бодлогын төлөө ирээдүйн 30 жилийн хөгжлийн бодлогыг тодорхойлж, 2050 оныг хүртэлх хугацаанд хүний хөгжлийг боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, шинжлэх ухаан, инновац, хүнд ээлтэй амьдрах орчин, хөдөлмөрийн зах зээл, монгол хүний удмын сан гэсэн долоон чиглэлд тэгш хүртээмжтэй дэмжихийг зорьж байна.

Хүн амын нийт тоо, түүнээс эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн тоо ба насны бүлэг бүрийн тоо хэмжэг багтаасан, тэдгээрийг нэгтгэн зурсан диаграммыг хүн амын нас, хүйсийн суварга гэдэг.

2050 он (5.2 сая)



ХҮНИЙ ХӨГЖИЛ

БОЛОВСРОЛ

ЗОРИЛТ 2.1 Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Чанартай боловсрол олгох, насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Насан туршдаа суралцахуйг дэмжсэн нээлттэй боловсролын тогтолцоог бэхжүүлэх үе

Боловсрол нь хүн төрөлхтний нийтийн баялаг, нийгэм-соёлын хөгжлийн үр дүн болохын зэрэгцээ боловсролын тогтолцоо нь аливаа улсын хөгжлийн бодлогын илэрхийлэмжийн суурь болдог. Хүн бүрд нас, хүйс, газар зүйн байршил, хэл, соёлын ялгаа, үндэс угсаа, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, хөгжлийн ялгаатай байдлаас үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш хүртээмжтэй насан туршдаа суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь төрийн урт хугацааны бодлогын эн тэргүүний зорилт байх ёстой билээ.

Монгол Улсын хөгжлийн бодлогод боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түлхүүр, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа тул Монгол Улсын төрөөс боловсролыг онцгойлон анхаарч хөгжүүлэхийг чухалчилж ирсэн. Боловсролын үйлчилгээг хүн бүр хүртдэг бөгөөд тус салбарт хэрэгжүүлж буй бодлогын үр дүн нь урт хугацаанд гардаг онцлогтой.

Боловсролын хөгжлийн дэлхий нийтийн чиг хандлагыг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 2030 баримт бичиг, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын төрөлжсөн байгууллага-ЮНЕСКО, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын боловсролын талаар баримталж буй чиглэл, олон улсын санаачилгуудад үндэслэн тодорхойлж байна. ЮНЕСКО боловсролыг мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс, итгэл үнэмшил, зөв хэвшлийг эзэмших үйл явц, түүний үр дүн гэж тодорхойлсон байдаг. Боловсрол нь тогтвортой хөгжлийн





зорилтыг хангахад хувирган өөрчлөгч хүчин зүйл болж байгаа бөгөөд боловсрол дахь тэгш бус байдлыг бууруулах, залуучууд насанд хүрэгчдэд мэргэжлийн боловсрол эзэмшигүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг гадуурхагдсан бүлгийн хүүхдийн боловсрол эзэмших эрхийг хангах, суралцах аюулгүй, таатай орчныг бүрдүүлэх, чанартай багш бэлтгэх зэрэг нь хүний хөгжлийн гол зорилтууд болж байна.

Өнөөгийн байдлаар боловсрол эзэмшиж буй хүүхэд, залуучуудын тоо нэг саяыг давсан нь Монгол Улсын хүн амын 30 гаруй хувийг эзэлж байна. Иймээс хүний хөгжлийн бүх асуудлыг боловсролын салбар тэр дундаа сургууль, багш дангаараа шийдвэрлэх боломжтүй. Иймд салбар дахь олон талт түншлэлийг бэхжүүлэн, төрийн зарим чиг үүргийг ТББ, мэргэжлийн холбоодод шилжүүлэх нь зүйтэй. Тухайлбал, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын үүрэг оролцоог нэмэгдүүлж, холбогдох үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдгээртэй хамтарч ажиллах чиглэлийг тодорхой болгон, үүрэг хариуцлагaa хуваан, түншлэлийг бэхжүүлж ажиллах хэрэгтэй юм. Цаашид боловсролын чиглэлээр суурь болон хавсарга судалгааг тогтмол хийж хэвших ба бүх шатны боловсролын сургалтын байгууллагын байршил, хүчин чадал, нөөц, нормативын нэгдсэн зураглал, судалгаа, шинжилгээний мэдээллийн санг бий болгон, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоог сайжруулах нь чухал.

Хувь хүн амьдралын хүрээнд мэдлэг, ур чадвар, чадамжаа дээшлүүлэх зорилгоор насан туршдаа суралцах бүхий л үйл ажиллагааг салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагаанд суурилан уян хатан, нээлттэй болгоно.

Боловсролд хүргэх арга зам
Боловсролтой иргэдийг зөвхөн анги, танхимиын сургалтаар бэлтгэдэг байдал өөрчлөгдж, цахимаар, телевиз, интернэтээр болон бие даан эзэмших арга замууд нэмэгдэн залуусын сонирхол, технологийн дэвшилтэй илүү уялдах болсныг харгалзах хэрэгтэй боллоо.

Зураг 3. Боловсролын салбарын эрх зүйн шинэчлэл



БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

Өв тэгш, үндэсний ухамсарт, эх оронч

Хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай

Эх хэлний боловсролтой, монгол хэл, бичгийн чадвартай, ургийн бичгээ мэддэг

Үнэт зүйлээ эрхэмлэдэг, бусдаас ялгарах онцлог давуу талаа мэддэг, таниулдаг

Олон улсын, үндэсний хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай

XXI зууны ур чадвар, мэдээлэл харилцааны технологийн мэдлэг, чадвартай

Бүтээлч сэтгэлгээ, оюуны өндөр чадвартай, дасан зохицох чадвартай иргэн

ХҮНИЙ ХӨГЖИЛ
БОЛОВСРОЛ

Чанартай боловсролын салшгүй хэсэг бол боловсролын мэргэжлийн байгууллага болон сургалтын байгууллагын удирдлага, менежмент, манлайллын чадавх байдаг. Иймд боловсролын засаглал, удирдлагын тогтолцоог тодорхой болгож, тасралтгүй сайжрах хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ. Мөн боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, хэрэглэж хэвшижээ.

Боловсролын чанарын өөр нэгэн чухал хэсэг бол хөтөлбөрийн чанар юм. Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлэхийн зэрэгцээ сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, агуулгыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн менежментийн циклийн дагуу үнэлж, сайжруулах болно. Боловсролын түвшин хоорондын хөтөлбөрийн залгамж холбоог хангах, салбарын түвшинд сургалтын багц цаг (кредит) харилцан хүлээн зөвшөөрөх, кредит дүйцүүлэх тогтолцоог бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжинэ. Ерөнхий боловсролын тулгамдсан асуудлын нэг болох сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүнийг сургалтын хөтөлбөртэй нарийн уялдуулан боловсруулж, чанарыг дээшлүүлэх, сурах бичгийг хэвлэх, түгээх тогтолцоог шинэчлэн боловсронгуй болгоно.

Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж хүүхдийн цэцэрлэгтийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг ирэх 30 жилд зохион байгуулна.

Зураг 4. Боловсролын салбарын хөгжил





Зураг 5. Дээд боловсролын салбарын хөгжил



Монгол Улсын хүн амын 14.2 хувь буюу 461,776 нь 0-5 насны иргэн бий. Үүнээс 0-2 настай 230.2 мянга, 3-5 настай 231.2 мянган иргэн байна. 2021-2022 оны хичээлийн жилийн төгсгөлд 237,231 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Энэ тоо жил ирэх тусам нэмэгдэх бөгөөд боловсролын салбарын хэтийн тооцоогоор сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоо 2030 онд 282.1 мянга, 2040 онд 335.0 мянга, 2050 онд 398.8 мянга болохоор байна. Сургуулийн өмнөх боловсролыг бага насны хүүхдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор цэцэрлэгийн барилга, байгууламж, хүүхдийн орны тоог эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үе шаттай нэмж, хүүхэд нэг бүрийн бага насны цогц хөгжлийг дэмжинэ. Бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд барихын тулд стандартыг мөрдүүлж, хүүхэд бүрд ээлтэй, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоо

2030 он

282.1 мянга

2040 он

335.0 мянга

2050 он

398.8 мянга

Хүснэгт 1. Дээд боловсролын хөтөлбөрт суралцачдын тоо (хэтийн тооцоо)

| Он | 2020 | 2035 | 2050 |
|--|---------|---------|---------|
| 18-22 насны хүн ам | 231,531 | 391,194 | 352,447 |
| Суралцач | 147,293 | 233,322 | 210,632 |
| Багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх | 18,450 | 30,904 | 27,656 |
| Хүмүүнлэгийн ухаан | 9,819 | 13,312 | 12,190 |
| Урлагийн төрөл, урлаг судлал | 3,657 | 6,254 | 5,500 |
| Хууль, эрх зүй | 8,644 | 13,648 | 12,091 |
| Нийгмийн шинжлэл | 10,211 | 13,756 | 12,842 |
| Худалдаа, бизнесийн удирдлага | 31,164 | 49,745 | 45,079 |
| Нийтийн мэдээлэл, сэтгүүл зүй | 1,939 | 2,740 | 2,522 |

| Он | 2020 | 2035 | 2050 |
|--|--------|--------|--------|
| Математик, компьютер | 5,206 | 8,012 | 7,295 |
| Үйлчилгээ | 7,133 | 10,530 | 9,666 |
| Байгалийн шинжлэл | 4512, | 7,290 | 6,606 |
| Анагаах ухаан | 14,390 | 26,411 | 23,441 |
| Инженер | 19,691 | 29,930 | 27,534 |
| Архитектур, хот төлөвлөлт | 4,644 | 9,259 | 8,121 |
| Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур | 4,231 | 6,137 | 5,658 |
| Бусад мэргэжил | 3,603 | 5,395 | 4,430 |

Эх сурвалж: БШУЯ, 2022

ХҮНИЙ ХӨГЖИЛ
БОЛОВСРОЛ


Цагаар өсөх Монголын үргс
Сургуулийн өмнөх боловсролд
хамрагдах хүүхдийн тоо жил
бүр 10 орчим мянгаар нэмэгдэж,
2050 онд 398.8 мянгад хүрнэ.

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 1-3, 4-6 настай хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын хэмжээг үндэслэн жил бүр шинэчлэн тогтоож, шаардлагатай нэмэгдэл төсвийг эцэг, эх, асран халамжлагчаас гаргуулах тогтолцоог бий болгоно. Ингэснээр хүүхэд бүхэн өдөр бүр хоол хүнсээрээ дамжуулан илчлэг, тэжээлийг хангалттай авснаар эрүүл чийрэг өсөж торних нөхцөл бүрдэх юм.

Боловсролын чанарын нэг чухал хүчин зүйл бол багшийн хүрэлцээ болон багшийн ажиллах орчин, нөхцөл юм. Цэцэрлэгийн багшийн ажлын чанарыг сайжруулах, хүүхэд бүрд хүрч ажиллах боломжийг нэмэгдүүлэх, мөн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх үүднээс бүлэг бүрд ээлжийн 2 багш ажиллуулахаар зорьж байна. Мөн хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдалд нийцсэн сургалтыг чанартай зохион байгуулахад зориулан тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтнийг цэцэрлэг бүрд ажиллуулахаар тусгасан. Түүнчлэн малчин өрхийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох явуулын гэр цэцэрлэг ажиллуулж, эцэг, эхчүүдийн боловсролыг дээшлүүлэн, тэдний оролцоонд түшиглэсэн хүүхдийн хөгжлийг дэмжих замаар боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Цэцэрлэгээс гадна хүүхэд харах үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, энэ төрлийн үйлчилгээ эрхлэх байгууллагад тавигдах шаардлага, стандартыг боловсруулан мөрдүүлэх замаар

Зураг 6. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоо, (хэтийн тооцоо)



Эх сурвалж: YCH, 2022




1-2 насны хүүхдүүдийг чанартай, хүртээмжтэй үйлчилгээнд хамруулна.

Олон улсын боловсролын хамтын ажиллагааны байгууллага ХХI зуунд бүтээлч байдал, шинийг санаачлах, шүүмжлэлт сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, харилцааны болон бусадтай хамтран ажиллах, мэдээллийн технологийн ур чадварууд хүн бүрд шаардлагатай болно гэж тодорхойлжээ. Түүнчлэн ЮНЕСКО ирээдүйд боловсрол ямар үүрэг гүйцэтгэхийг олон нийтийн оролцоотойгоор тодорхойлох санаачилгыг 2019 оноос хойш хэрэгжүүлж байгаа бөгөөд сурган, заах арга зүй нь хамтын ажиллагаа, эв нэгдлийн зарчимд тулгуурласан, сургалтын хөтөлбөр нь экологи, соёл, салбар дундын олон талт мэдлэгийг эзэмшихийн зэрэгцээ мэдлэгээ бүтээлчээр ашиглах ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн, багш болон сургалтын орчныг чухалчилсан байхад чиглэж байна.

Хүүхэд, залуучууд чанартай боловсролыг суралцах орчин бүрдсэн, ая тухтай орчинд эзэмших зорилтыг дэвшүүлсэн. Үүний тулд сургуулийн насны хүүхдүүдийн өсөлтийн тооцоололд үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламж, суудлын тоог үе шаттайгаар нэмэгдүүлж анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хургэхийг зорьж байна. Мөн сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал,

Зураг 7. Ерөнхий боловсролын салбарын хэтийн тооцоо



Эх сурвалж: УСХ, 2022

ХҮНИЙ ХӨГЖИЛ
БОЛОВСРОЛ



Боловсролын салбарын эн тэргүүнд анхаарах ёстой асуудал бол суралцагчийн нийгэм, эдийн засгийн байдал, хүйс, гэр бүлийн нөхцөл зэргээрээ ялгамжтай байхаас үл хамааран сурч хөгжих тэгш боломжийг бүрдүүлэх явдал юм.




цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг стандартын дагуу тохижуулж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохируулгат орчин бүрдүүлж, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг хүүхэд, хэрэглэгчдэд ээлтэй болгох ажлуудыг үе шаттайгаар төлөвлөж хэрэгжүүлнэ. Түүнчлэн сурагч болон багшид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, суралцагчдад мэргэжлээ сонгох, ирээдүйгээ төлөвлөхөд нь зөвлөн туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйч, мэргэжилтнийг сургууль бүрд ажиллуулах, тухайн мэргэжилтнийг бэлтгэхээр зорин ажиллаж байна.

ЮНЕСКО боловсролын салбарын 2050 он хүртэлх ирээдүйн чиглэлийг тодорхойлсон тайланд багшиг мэдлэг бүтээх үйл явц, боловсролын болон нийгмийн өөрчлөлтийг бий болгоход гол үүрэг гүйцэтгэгч гэж тодорхойлсон. Боловсролын салбарын хөгжлийн цөм болсон хүний нөөцийн хөгжлийг дэмжиж, чадахуйн зарчмаар албан тушаал, мэргэжлийн хөгжлөө тодорхойлох боломжтой карьерын систем бий болно. Ингэхдээ бүх шатны сургалтын байгууллагын багшийн чадамжийн хүрээг мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны, МХХТ-ийн, гадаад хэлний гэх мэт чадваруудаар ялган тодорхойлж, багшийн хөгжил, хүний нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх боломжтой. Боловсролын мэргэжлийн байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, тэдэнд зориулсан хөтөлбөр боловсруулах, боловсролын салбарын удирдлага, бодлого, төлөвлөлтийн чиглэлээр мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачид бэлтгэх, тэдний мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжихэд анхаарна.

Боловсролын салбар дахь тэгш байдал, тэгш хүртээмж нь зайлшгүй анхаарах нэг асуудал бөгөөд суралцагчийн нийгэм, эдийн засгийн байдал, хүйс, гэр бүл ямар байхаас үл хамааран сурч хөгжих ижил, тэгш боломжийг бий болгох тухай юм. Боловсролын тэгш байдлаар дэлхийд Нидерланд улс тэргүүлж, Латви, Ирланд, Испани зэрэг улс удаалдаг. Эдгээр орнууд боловсролын тэгш байдлыг шударга ёс, боловсролын стандарт гэсэн хоёр хэмжүүрээр хэмждэг бөгөөд сургуулийн насын олон хүүхэдтэй айлд дэмжлэг үзүүлэх, мөн төлбөрийн чадваргүй ч амжилттай төгсөгчдөд Засгийн газраас тэтгэлэг олгох, сургуулийн ажилтнуудаа мэргэшүүлэх, сургууль завсардсан болон хичээлээс хоцрогдсон хүүхдүүдэд зориулсан мэргэжлийн баг бүрдүүлж ажиллуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, завсардах эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулахаар хөгжлийн бодлогод тусгасан.



Зураг 8. Ерөнхий боловсролын сургуулийн хүний нөөцийн хэтийн тооцоо



Эх сурвэлж: БШУЯ, УСХ, 2022

Боловсролын салбарт цахим сургалт болон мэдээллийн технологийн ололт, амжилтыг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагын үүднээс "Боловсролын дата төв, сүлжээний удирдлагын нэгдсэн төв"-ийг байгуулсан. Ингэснээр төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 90 орчим хувийг холбосон шилэн кабелийн нэгдсэн сүлжээг үүсгэнсээр салбарын мэдээллийн ургтал, агуулгын хэрэглээний ачааллыг даан ажиллах мэдээллийн технологийн дэд бүтэц бүрдجээ. Боловсролын салбарын үйл ажиллагааг цахимжуулах, иргэдэд шуурхай үйлчлэх, салбарын мэдээллийг найдвартай болгох, онлайн сургалт болон мэдээллийн технологид тулгуурласан сургалтын шинэ хэв маяг нэвтрүүлэхэд уг төв гарааны суурь нь болж байна.

Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэхэд хөгжлийн бодлого чиглэж байна.

Өмнө дурдсан сорилт, бэрхшээлийг шийдвэрлэх, мөн боловсролын чанарыг ахиулах зорилгоор боловсролын салбарын шинэчлэлийг "Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгж боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх" хэмээн тодорхойлсон билээ.

Чадварлаг багш Чанартай боловсрол

Хангалиун сайхан амьдрахад хүний боловсролын түвшин шийдвэрлэх нөлөөтэй. Боловсролын тогтолцоог чанарын шинэ шатанд гаргахад чадварлаг багш нараас бүрдэх хүний нөөцийг төрийн бодлогоор шат дараатай бэлтгэх нь чухал.

БҮСИЙН ТӨРӨЛЖСӨН СУРГАЛТ-ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ- ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР



Аймаг, орон нутаг дахь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, технологийн коллеж, их, дээд сургуулиуд, сургалт-эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолборыг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, тухайн орон нутгийн нийгэм, эдийн засийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан хөгжүүлнэ. Тухайлбал, Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийн харьяа Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн Агро-экологи, бизнесийн сургуулийг түшиглэн хөдөө аж ахуй, газар тариалангийн, Өмнөговь аймагт ШУТИС-ийн харьяа Геологи, уул уурхай, технологийн сургуулийг шинээр байгуулах, Орхон аймаг дахь ШУТИС-ийн харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг түшиглэн уул уурхай, технологийн чиглэлээр төрөлжүүлэн, цогцолбор болгон хөгжүүлнэ.

Зураг 9. Аймаг, орон нутаг дахь их, дээд сургуулиуд





ХӨГЖЛӨӨС ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ



Боловсролын бүх түвшинд суралцагчид аюулгүй, эрүүл орчинд хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид нөхцөлд сургууль дээрээ хүүхэд хөгжлийн цогц үйлчилгээг авч, суралцахуйн зохих дэмжлэгтэйгээр хүртээмжийн ямар ч саадгүйгээр сурч боловсрох тэгш боломжийг баталгаажуулна. Тэгш хамарсан чанартай боловсролын тогтолцоонд ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн хөгжлийг дэмжиж, шударга, эрх тэгш, эв эе цогцолсон, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх нийгмийг бүтээнэ.

Зураг 10. Боловсролд тэгши хамруулах зарчим

- | | | | | | |
|----------|---|----------|------------------------------|----------|--------------------------------|
| 1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн | 2 | Малчин өрхийн гишүүн | 3 | Шилжин суурьшсан өрхийн гишүүн |
| 4 | Үндэсний цөөнх хэл, соёлын ялгаатай иргэн | 5 | Орлого багатай өрхийн гишүүн | 6 | Сургууль завсардсан иргэн |
| 7 | Сурлагын хоцрогдолтой суралцагч | 8 | Жендер | 9 | Бусад зорилтот бүлэг |



Тусгай хэрэгцээт болон мэргэжлийн багш



Хүүхэд, хэрэглэгчдэд ээлтэй стандартын шаардлага хангасан хүртээмжтэй орчин, барилга байгууламж дэд бүтэц



Суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан сурх бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн



Эцэг эх, асран халамжлагчдын оролцоонд түшиглэсэн хүүхдийн хөгжил



Бусад шаардлагатай дэмжлэг

БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЖ ЧАДАХГҮЙ, ЭРСДЭЛТ БУЛГИЙН СУРАЛЦАГЧ НЭГ БУРД ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГИЙГ ҮЗҮҮЛЖ, БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛНА.

ХҮНИЙ ХӨГЖИЛ

ЭРҮҮЛ МЭНД

ЗОРИЛТ 2.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих үе

Эрүүл байхын эх үндэс бол амьдралын зөв дадал зуршил. Хувь хүний өдөр тутмын амьдралын зөв хэмнэл буюу нойр, хоол, дасгал хөдөлгөөн нь эрүүл байх нөхцөл боловч эрүүл мэндийн боловсрол олгох, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зохистой үйлчилгээг цаг алдалгүй хургэх тогтолцоо, дэмжлэг эрүүл байхад зайлшгүй шаардлагатай.

.....


Эрүүл мэндийн бодлого ба тогтолцоо нь улс орны бүх нийтийн эрүүл мэндийн зорилгод хүрэхийн тулд нийгэм өөрөө хэрхэн бүтцээ зохион байгуулж, сайжруулж байгаа болон оролцогч талууд бодлогын үр дүнг дээшлүүлэх зорилготой. Эрүүл мэндийн тогтолцоо гэдэг нь эрүүл мэндийг дэмжих, хадгалах, сэргээх зорилготой бүх байгууллага, хүмүүс, тэдний үйлдлийн цогц юм. Аливаа улс орны эрүүл мэндийн салбарын хөгжлийг хангахад эрүүл мэндийн санхүүжилт, засаглал гэх мэт өргөн хүрээний ойлголтоос эхлээд төрийн болон хувийн эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ, түүний хэрэгжилтийг тойрсон олон асуудлуудыг шийдэх хэрэгтэй болдог.

Манай орны нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал сүүлийн 10 жилийн дунджаас 16.6 хувиар нэмэгджээ. Нийт хүн амын 94 хувь нь эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдаж байна. Даатгалын сангаас жилд дунджаар давхардсан тоогоор 6.0 гаруй сая хүнд тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний зардлыг олгож байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын тоон мэдээллээр урьдчилан сэргийлэх үзлэг,





Зураг 11. Дундаж наслалт



Эх сурвалж: Дэлхийн банк, 2021

оношилгоо шинжилгээнд жилд 293,318 даатгуулагч хамрагджээ. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтын гүйцэтгэлийн эрүүл мэндийн үзүүлэлт 66.3 байгаа нь Номхон далайн баруун эргийн бүсийн дундаж үзүүлэлтээс 2.3 хувиар доогуур байна.

Монгол Улсад эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусlamж үйлчилгээний хамралт 85 хувтай байна.

Гэвч амьдралын буруу хэвшил, хорт зуршил, буруу хооллолт, хөдөлгөөний идэвхгүй байдлаас шалтгаалсан халдварт бус өвчин нас баралтын 77 хувийг эзэлдэг бөгөөд уг өвчлөлд эрүүл мэндийн салбарын нийт төсвийн 70 гаруй хувь зарцуулагддаг. Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар авч үзвэл жилд 16.8 мяняган нас баралтын тохиолдол бүртгэгдсэнээс 60 хувь нь эрэгтэйчүүд, 40 хувь нь эмэгтэйчүүд байна. Нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувь өсөж байгаагийн зэрэгцээ зүрх судасны өвчлөл болон хавдраас шалтгаалсан нас баралтад анхаарах шаардлагатай байна.

Халдварт бус өвчин, түүнээс шалтгаалсан нас баралт их байгаа нь эрүүл, идэвхтэй амьдралын зөв хэв маягтай Монгол хүнийг төлөвшүүлж, эрүүл мэнд, биеийн тамир, спортын үйлчилгээг амьдралын нэг хэсэг болгох зарчимд суурилан хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Энэ нь урьдчилан сэргийлэх, эрт оношлох бодлогын буюу нийгмийн эрүүл мэндийн тусlamжийн гол цөм юм. Монгол хүний эрүүл байдлыг удаан хугацаанд хадгалах нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний суурь тавигдсан хэдий ч өндөр хөгжилтэй улс орнуудын тогтолцоотой адил төлөвшөөгүй байна. Иймд эрүүл мэндийн салбарт урьдчилан сэргийлэх, оношлох үндэсний тогтолцоог сайжруулах, иргэдийн зүгээс тогтмол хамрагддаг

Дундаж наслалтаар тэргүүлэгч Япон ба Монгол

Дэлхийн улс орнуудын дундаж наслалтыг 2020 оны байдлаар харвал дэлхийн дундаж нь 73.2 байна. Япон улсын хувьд 85.03 байгаа бөгөөд дэлхийн дунджаас 12.2 насаар их, Монгол улс дэлхийн дунджаас 2.7-оор бага байна.



1 ИХ ЭМЧИД
НОГДОХ ИРГЭДИЙН
ТОО ДЭЛХИЙ
ДАХИНД

Дэлхий

637

Хойд америк

384

Европ

256

Латин америк

434

МОНГОЛ

253


Эх сурвалж: УСХ, 2022

ХҮНИЙ ХӨГЖИЛ
ЭРҮҮЛ МЭНД

дадал хэвшлийг бий болгох зорилтыг тусгасан. Ингэснээр эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамрагдах, зөв хооллолт, дархлаагаа дэмжих, дасгал хөдөлгөөн хийх зэрэг эрүүл дадал хэвшлийг иргэдэд бий болгохыг зорьж байна. Мөн урьдчилан сэргийлэх анагаах ухааны чиглэлээр ажиллах мэргэжилтнийг олон улсын жишигт нийцсэн хөтөлбөрөөр бэлтгэх, хүн бүрд үйлчлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг орон нутаг бүрд байгуулах болно. Архи, тамхи, мансууруулах бодис, дэлгэцийн хамаарал зэрэг эрсдэлт зан үйлийг бууруулах үүднээс судалгаа, сургалт, мэдээллийг бусад салбарт зохион байгуулна. Түүнчлэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хөтөлбөрт эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх агуулгыг тусган эрүүл амьдралын зан үйлийг хэвшүүлнэ. Хүүхэд чөлөөт цагаараа эрүүл мэнд, бие бялдрын зөв дадал эзэмших орчин, нөхцөлийг орон сууцны гадна талбай, сургуулийн орчинд бүрдүүлнэ.

Хүн амын дундах халдварт өвчлөлийн хувьд амьсгалын замын

Зураг 12. Нас баралтын тэргүүлэх шалтгаан (2021 он)



Эх сурвалж: УСХ, 2022



зураг 13. Эрүүл мэндийн тогтолцооны шинэчлэл



халдварт өвчин 36.7%, бэлгийн замаар дамжих халдварт 36.5%, гэдэсний халдварт өвчин 19.4%, зоонозын халдварт өвчиний тохиолдол 0.9%-ийг эзэлж байна. Иймд ирэх 30 жилд халдварт өвчиний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчиний тархалтыг бууруулахаар зорьж байна. Түүнчлэн халдварт өвчиний дэгдэлт зэрэг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үед эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.

Эрүүл мэндийн салбарт анхаарах нэг чухал асуудал бол үйлчилгээний чанар юм. Олон улсын стандартын дагуу хүн амын эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо, үйлчилгээний чанарыг эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм тария, үйлчилгээ нь шинжлэх ухаан, анагаах ухааны шаардлагад тохирсон сайн чанартай байх, дадлага туршлагатай эмнэлгийн ажилтнуудаар хэмждэг. Түүнчлэн олон улсад үйлчлүүлэгч нэг бүрийн онцлог хэрэгцээ, сонголтод нийцсэн буюу үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг чухалчилж байна.

Манай улс ирэх 30 жилийн хөгжлийн бодлогод төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж, хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжихээр тусгасан. Мөн оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологи бүхий олон улсын жишигт нийцсэн

ХУН АМЫН ДУНД ЗОНХИЛОХ ӨВЧИН

ХАЛДВАРТ ӨВЧИН

- Амьсгалын замын халдварт өвчин
- Бэлгийн замаар дамжих халдварт өвчин
- Гэдэсний халдварт өвчин
- Зоонозын халдварт өвчин

ХҮНИЙ ХӨГЖИЛ
ЭРҮҮЛ МЭНД

төвүүдийг байгуулах замаар иргэд эх орондоо цогц оношлуулах боломжийг бүрдүүлнэ. Мөн Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулж хөгжүүлнэ.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд шилжүүлж, эрүүл мэндийн байгууллагын хараат бус, бие даасан удирдлагыг дэмжих ба хувийн болон улсын даатгалыг хослуулах замаар эрүүл мэндийн даатгалын санг нэмэгдүүлэх болно. Ингэснээр үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн тусlamжийг бий болгох, иргэд эрүүл мэндийн асуудлаас шалтгаалан санхүүгийн эрсдэлд орохоос

Зураг 14. Эрүүл мэндийн нэгдсэн тогтолцоо

НЭГ ХУДАЛДАН АВАГЧИЙН ТОГТОЛЦОО



Эрүүл мэндийн байгууллагуудад гүйцэтгэлийн санхүүжилт нэвтэрснээр эрүүл мэндийн чанартай, тусlamж, үйлчилгээг даатгуулагчид үзүүлж, улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийн хооронд шударга өрсөлдөөн бий болохын зэрэгцээ иргэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ авахдаа төлөх төлбөрийн хэмжээ буурч, эрүүл мэндийнхээ улмаас санхүүгийн дарамтад орох асуудлыг бууруулах ач холбогдолтой. Эрүүл мэндийн байгууллагууд үзүүлсэн тусlamж, үйлчилгээнийхээ тоо, чанарын гүйцэтгэлд тулгуурлан санхүүжилтээ авдаг болно.



Зураг 15. Эрүүл мэндийн салбарын хөгжил



Монголын уламжлалт
анагаах ухааныг орчин
үеийн анагаах ухаантай
хослуулан хөгжүүлнэ.



Иргэд жил бүр урьдчилан
сэргийлэх цогц үзлэг,
шинжилгээнд хамрагддаг
соёлыг хэвшишүүлнэ.



Эрүүл мэндийн урт
хугацааны тусlamж
үйлчилгээ болох сэргээн
засах, сувилахуй,
хөнгөвчлөх тусlamж
үйлчилгээг хөгжүүлнэ.



Яаралтай түргэн
тусlamжийн үндэсний
тогтолцоог шинэчилнэ.



Бүх шатны эмнэлэг, эрүүл
мэндийн байгууллагын
барилга байгууламж, дэд
бүтцийг сайжруулна.



Олон улсын жишигт
нийцсэн эрүүл мэндийн
төвийг төрөлжүүлэн
байгуулна.



Эмийн чанар, аюулгүй
байдлын цахим тогтолцоог
бүрдүүлнэ.



Анагаах ухаан, эрүүл
мэндийн салбарын тусlamж
үйлчилгээг хиймэл оюун
ухаанд тулгуурлан хөгжүүлнэ.



Өндөр өртөгтэй, нарийн
төвөгтэй, оношилгоо,
эмчилгээ хийлгэх тохиолдолд
зардлыг эрүүл мэндийн
даатгалын сангаас олгох үйл
ажиллагааг өргөжүүлнэ.



Онцгой албан татварын
тодорхой хувийг эрүүл
мэндийг дэмжих санд
төвлөрүүлнэ.



Төрийн өмчийн эмнэлгийг
санхүүжилтийн болон
удирдлагын бие даасан
хэлбэрт шилжүүлнэ.



Гүйцэтгэлд суурилсан
санхүүжилтийг бүрэн
нэвтрүүлнэ.

Эх сурвалж: ЭМЯ, 2020

урьдчилан сэргийлэх, төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэгт
олгож байгаа эрүүл мэндийн даатгалын зардлын ялгаа арилах
боломжтой болно.

Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэх замаар
эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, бүртгэл,
импорт, түгээлт, цахим хяналтын тогтолцоо сайжирна. Мөн
эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухаан
буую төле медициныг өргөжүүлж, эрүүл мэндийн тусlamж,
үйлчилгээний бүх түвшинд ашиглана. Технологийн шинэчлэлт
хөрөнгө оруулалт хийж, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
Цахим үйчилгээ, техник, технологи сайжирснаар эрүүл мэндийн
үйлчилгээний чанар, хүртээмж, хяналтад ахиц, дэвшил
гарагаас гадна алслагдмал сум, орон нутаг, хот, нийслэлд
амьдарч байгаа хүмүүст үзүүлэх тусlamж, үйлчилгээний
хүртээмж, чанар ижил түвшинд хүрэх боломж бүрдэх юм.


Эрүүл мэндийн цахим үйлчилгээ
Орчин үеийн технологийн
дэвшлийг эрүүл мэндийн үзлэг,
onoшилгоо, эмчилгээ, хяналтад
өргөнөөр нэвтрүүлснээр иргэдэд
түргэн шуурхай, өндөр чанартай,
хямд төсөр эмнэлгийн үйлчилгээ
хүргэх тогтолцоог бүрдүүлэхэд
чухал нөлөөтэй.

ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО



Иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд жил бүр хамрагддаг дадал, хэвшилтэй болно. Эрүүл мэндийн даатгалдаа бүх байгуулага, иргэд бүрэн хамрагдаж, цогц үзлэгт хамрагддаг соёлтой болно. Үзлэг, шинжилгээ явуулах лаборатори, хүний нөөцийг бэлтгэхэд анхаарч, хөгжүүлэн олон улсын магадлан итгэмжлэлд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ. Алсын зайн оношилгоо, зөвлөгөө авах боломжийг хангана. Ингэснээр хүний хөгжлийн суурь хангагдаж, идэвхтэй амьдралын чанар дээшлэх төдийгүй эрүүл мэндийн салбарын яаралтай тусламж, үйлчилгээний ачаалал буурч, гаднын улсад эмчилгээ хийлгэхээр алс орныг зорих иргэдийн тоо багасна.


Зураг 16. Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин




НЯЛХСЫН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН ЭХИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН



10,000 ХҮН АМД НОГДОХ ВИРУСТ ГЕПАТИТИЙН ӨВЧЛӨЛ



ЦУСНЫ ДАРАЛТ ИХСЭХ ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН ХУВЬ



Эх сурвалж: Монгол Улсын Засгийн газар, 2021



ДАРХЛААГАА ДЭМЖСЭН ЭРҮҮЛ ЗӨВ АМЬДРАХ ДАДАЛ




Эрүүл мэндэд сэргеөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах, архи, тамхи, эм, чихэрлэг ундааны онцгой албан татварын тодорхой хувийг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлж, хүн амыг өвчинөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг бага наснаас хэвшүүлнэ. Аймаг, сум, дүүрэг, хороо бүрд “Эрүүл зөв амьдрал” төвүүдийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр ажиллуулахыг дэмжинэ. Иргэд зөв хооллолт, бие бялдраа хөгжүүлэх, дасгал хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх дадал хэвшилд суралцана.

Зураг 17. Эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлс



1. Эрүүл зөв хооллох
2. Байнгын дасгал хөдөлгөөнтэй байх
3. Өөрт тохирсон биеийн жинг хадгалах
4. Согтууруулах ундаа, алкоголийн төрлийн зүйл маш бага хэмжээгээр хэрэглэх
5. Огт тамхи татахгүй байх дадлыг хүн бүр хэвшүүлэх нь чухал юм.

ХАЛДВАРТ БУС ӨВЧЛӨЛ-ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС, ДЭМБ, НДББ



25% ТАМХИДАЛТ | 28% ТАРГАЛАЛТ | 5% АРХИНЫ ХЭРЭГЛЭЭ | 42% хөдөлгөөний хомсдол

Илүү урт удаан насалж, эрүүл амьдрахын тулд дор хаяж тамхи татахгүй байх, согтууруулах ундаа, алкоголийн төрлийн зүйл бага хэрэглэх мөн байнгын дасгал хөдөлгөөнтэй байх чухал.

Амьдралын зөв дадал, хэвшил, дархлаагаа дэмжих нь хүний дундаж наслалтад хамгийн ихээр нөлөөлдөг болохыг эрдэмтэд батлаад байна.

ХҮНИЙ ХӨГЖИЛ

ГЭР БҮЛ

ЗОРИЛТ 2.3 Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлд ээлтэй орчныг бүрдүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Нийгмийн идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг тогтвортой дэмжих үе

Гэр бүл нь хүний хөгжлийн анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж, соёл, уламжлал, нийгмийн үнэт зүйл өвлөгөн шинэчлэгдэх, аж төрөх ёсны бичил ахуй юм. Гэр бүлийн амьдралын түвшнийг тасралтгүй дээшлүүлж, гэр бүлийн харилцаа, ёс зүйн эрүүл орчин, түүний нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх нь хүnlэг энэрэнгүй нийгмийн суурь болно.

Гэр бүл нь нийгмийн анхдагч үндсэн нэгж. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах нь нийгмийн тогтвортой байдал болон хүний хөгжлийг дэмжихэд чухал юм. Монгол Улс 2021 оны байдлаар 920 мянган өрхтэй болж, жилд дунджаар 1.0-1.3 хувиар өсөж байна. Тэжээлгэгч насны хүн ам буюу 0-14 болон 65-ээс дээш насны хүн ам тогтвортой байх эсвэл буурч байхад хөдөлмөрийн насны хүн ам өсөж байгаа үеийг хүн амзүйн цонх үе гэдэг. Монгол Улсад хүн амын цонх үе харьцангуй олон жил үргэлжлэх тооцоо байгааг хүн амзүйн бүтцийг харуулсан зураглалаас харж болно.

Цонх үед хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх, иргэдийг ажилтай, орлоготой байхад хөрөнгө оруулалт хийх нь чухал бөгөөд үүнийг хүн амзүйн эхний урамшуулал гэж үздэг. Харин тэтгэвэрт гарагсдын тоог урьдчилан харж, хувь хүн болон төрийн зүгээс ахмад настнуудын тэтгэврийн орлогыг бүрдүүлэх зорилгоор хуримтлал бий болгохыг дэмжих нь хүн амзүйн хоёрдогч урамшууллыг бий болгож байдаг. Хүн ам зүйн эхний урамшуулал нь түр зуурын байдаг бол хоёрдогч урамшуулал






нь байнгын байдаг. Иймд хүн амын өсөлийг тогтвортой хэмжээнд байлгах, хөдөлмөрийн насын хүмүүсийг ажилтай, орлоготой байхыг дэмжих, мөн наслжилтад бэлтгэх асуудлууд чухлаар тавигдаж байна.


Монгол улсад гэр бүл цуцлалт жилд дунджаар 2.6 хувиар өсөж байгаа нь зайлшгүй анхаарах шаардлагатай нийгмийн асуудал

Зураг 18. Гэрлэлтээ бүртгүүлсэн хосын тоо, насын булгээр



Эх сурвалж: УСХ, 2022

Зураг 19. Гэр бүл цуцалтын тоо, байсан хугацаагаар



Эх сурвалж: УСХ, 2022


ХҮНИЙ ХӨГЖИЛ
ГЭР БҮЛ

болж байна. Гэр бүл цуцлалтыг гэр бүл байсан хугацаагаар судлан үзэхэд гэрлэлтээ цуцлуулсан нийт 4,262 гэр бүлээс дийлэнх буюу 64.7 хувийг 10 ба түүнээс дээш жил амьдарсан гэр бүл эзэлж байна. Жилд 10,000 орчим хүүхэд гэр бүл салалтын үр дагаврыг амсаад хүрч байна. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэмт хэрэг, хүчирхийллийн золиос болох тохиолдол жилээс жилд нэмэгдэх болсон. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 10 хүн тутмын 7 нь бие машбодын хүчирхийлэлд өртдөг. Дээрх тоо баримт нь гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлэх, хүүхдийн аюулгүй, таатай өсгөх, хөгжих, сурч боловсрох орчныг бүрдүүлэх шаардлага тулгарсныг харуулж байна.

Гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих, гэр бүлийн хөгжил, үр хүүхдээ асран хамгаалахад эцэг, эх, асран хамгаалагчийн жигд оролцоог хангах, орон сууцтай болохыг дэмжих, гэр бүлд зориулсан үйлчилгээний сүлжээг бий болгох, зан үйлийн эерэг орчин бүрдүүлэх зохицуулалтыг төр анхаарах шаардлагатай юм. Мөн гэр бүлийн харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг уялдаатай болгох замаар өмчлөл, хүчирхийлэл зэрэг хүний эрх зөрчигдөхтэй холбоотой маргааныг зохистой шийдэх, эмзэг бүлгийн нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг гэр бүлд төвлөрүүлэхэд анхаарах нь чухал юм.

Эдгээр бодит асуудал, хэрэгцээг тооцон, судалсны үндсэн дээр гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт,

Зураг 20. Нийгмийн бүлгүүдийн хөгжил





хүний хөгжлийг дэмжих, гэр бүлд ээлтэй орчноо бүрдүүлэхэд чиглэсэн бодит үйл ажиллагааг тусгасан.

Тухайлбал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлж, хүүхдийн тоо, наснаас хамааран хөнгөлөлт өдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоо бүрдүүлнэ. Бүтэн бус цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнлас ажиллахыг дэмжих замаар ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох буюу ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. Мөн гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Залуу гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит хуримтлал бий болгоно. Мөн залуу гэр бүлд сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Ийнхүү гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлснээр хүн амын тогтвортой өсөлтийг хангах, гэр бүл бүр аз жаргалтай амьдрах суурь нөхцөл бүрдэх болно.

Манай улс 2050 он хүртэл хүн ам, гэр бүлийн бодлогын хувьд хүхэд, залуучууд, гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан гэсэн үндсэн таван хүрээнд хэрэгжих хоорондоо уялдаа холбоо бүхий урт хугацааны, шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгаа билээ.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хууль, эрх зүйн орчныг сайжруулж, нийгмийн амьдралд саадгүй оролцох боломжийг бүрдүүлнэ.

АХМАД НАСТАН

Ахмад настны хөгжлийг дэмжих шинэ төрлийн үйлчилгээг бий болгож, урт хугацааны тусламж үйлчилгээг нэвтрүүлнэ.



ТОГТВОРТОЙ, АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ



Гэр бүлд ээлтэй орчин, ажилтай орлоготой болгох хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хүн амын төрөлтийг дэмжсэн нийгмийн хамгааллын бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Эцэг эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох, ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. Залуу гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллана.



Гэр бүлийн үнэ цэн

Гэр бүлийн гишүүд хөдөлмөр эрхэлж, гэр бүлийнхээ эдийн засгийн хэрэгцээг хангах үүрэгтэй бөгөөд үүгээрээ дамжуулан нийгмийн баялгийг үйлдвэрлэхэд оролцдог. Энэ үүрэг, хэрэгцээг төрийн бодлогоор хангах нь тогтвортой гэр бүл бүрдүүлэх зорилт болно.



ХҮҮХДИЙН ЭРХ, ХӨГЖИЛ



Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана. Төрийн болон гэр бүлийн хүрээнд гарч байгаа хүүхдэд хамааралтай шийдвэр хүүхдийн сайн сайханд нийцэх эсэхийг тооцож гаргадаг соёлд бүх нийтээр суралцана.



Хүүхдэд ээлтэй, тэгш боломжийг судалгаатай шийдвэрлэнэ.

Бүх хүүхдийн нөхцөл байдал, нэн ялангуяа эмзэг байдлын нэн хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийн нас, хүйс, хөгжлийн онцлог, хэрэгцээ, газарзүйн байршил, яс үндэс, нийгэм-эдийн засгийн байдлын талаар дүгнэлт шинжилгээг тогтмол хийнэ.

ХҮНИЙ ХӨГЖИЛ

ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦ

ЗОРИЛТ 2.4. Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Үндэсний шинжлэх ухаан, инновацыг дэлхийн зах зээлд гаргах тогтолцоог бүрдүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Олон улсад өрсөлдөх чадвартай шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлэх үе

Аливаа улс орон өөрийн эрдэмтэн, мэргэдийг дэмжих замаар хөгжлийн замналаа батжуулдаг. Өнөөдөр манай улсад нэг сая хүнд ногдох эрдэм шинжилгээний ажилтны тоо ойролцоогоор 500 гаруй байна. Тэгвэл 1.0 сая хүнд оногдох эрдэм шинжилгээний ажилтны тоо АНУ-д 4,600, Японд 5,500 байдаг. Дэлхийн дундаж ойролцоогоор 1,500 орчим байна. Шинжлэх ухаан, технологийн хөгжлийг эрдэмтдийн чадвар, олон улсад танигдсан байдал, тэдний бүтээл эдийн засгийн эргэлтэд орсон түвшнийг инновацаар илэрхийлж болно.

Мэдлэгийг өдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бий болгох шаардлага энэ цаг үед чухал байна. TWAS /The World Academy of Science/ нь шинжлэх ухаан, технологийн чадавхаар улс орнуудыг ангилахад Монгол Улс шинжлэх ухааны хөгжлөөрөө хоцрогдсон 66 орны тоонд бичигджээ. Монгол Улсын хувьд шинжлэх ухаан, инновацын хөгжилд зарцуулж буй санхүүжилт нь тус салбарыг хөгжлийн түлхүүр болгон хөгжүүлэхэд бүрэн дэмжлэг болж чадахгүй байна. ЮНЕСКО-ийн 39 дүгээр ерөнхий хуралдаанаас “Шинжлэх ухаан, технологи, инновац дахь өөрийн хүчин чармайлтыг интеграачлах зорилгоор гишүүн орны Засгийн газрууд хүний нөөцийн болон байгууллагын потенциалыг бий болгон, ул суурьтай бэхжүүлэх шаардлагатай” гэсэн зөвлөмжийг гаргасан. Үүнд төр, хувийн болон ашгийн бус эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа бүхий л салбарын шинжлэх





ухааны судалгаа, боловсруулалтыг хөхиүлэн дэмжих, шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын үндэсний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, байгууллага болон бүтцээр хангах зэргийг тусгасан.


Өнөөдөр шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлд хүний хөгжил, хүрээлэн буй орчин, хөдөө аж ахуйн эрчимжүүлэлт, аж үйлдвэрийн дэвшилтээ технологи, өндөр технологи зэрэг багтаж байна. Харин инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд мэдээллийн технологи, шинэ материалын технологи, биотехнологи/үйлдвэрлэлийн технологи, сэргээгдэх эх үүсвэртэй эрчим хүчний технологи, үндэсний онцлог бүхий соёлын инновац, бүтээлч үйлдвэрлэл зэрэг орж байна.

Мэдээлэл технологи, шинжлэх ухаан, инновацын салбар хөгжин цэцэглэж, хүн төрөлхтний хэрэглээ болон ирээдүйн чиг хандлага

Шинжлэх ухаанд сууриссан хөгжил

Улс орны хөгжил өөрсдийн шинжлэх ухааны хөгжлийн түвшнээс шууд хамаардаг болсоор байна. Иймээс шинжлэх ухааны судалгааны ажлыг төрийн бодлогоор дэмжих, төсвийн санхүүжилтийг жилээс жилд нэмэгдүүлэх шаардлагатай.

Зураг 21. Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулж буй хөрөнгө



■ Шинжлэх ухааны салбарт зарцуулж буй зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь (2017)

■ Боловсролын салбарт зарцуулж буй зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь (2018)

Зураг 22. Шинэ санаачилгын үндэс



цаг үргэлж шинэ ололт амжилтыг нэхэн шаардаж байна. Эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны үндсэн чиглэлийг тогтоож, үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, судалгааны лабораториудын менежмент, зохион байгуулалтын эрх зүйн шинэ орчин бүрдүүлж, хэрэгжилтийг хангах зэрэг олон шинэчлэлийг хийх шаардлагатай байна.

Улсын төсвөөс шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд зарцуулж байгаа санхүүжилтийн хэмжээ хангалттай хэмжээнд өсөн нэмэгдэхгүй байгаагаас үүдэн эрдэм шинжилгээний ажлын цар хүрээ хумигдаж, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүн, судалгаа боловсруулалтын ажлын өрсөлдөх чадвар хангалтгүй түвшинд байна. Тус салбарын гол бүтээгдэхүүн болох шинэ мэдлэг, технологи нь үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрэч, улсын эдийн засагт дорвitoй хувь нэмэр оруулж чадахгүй байна. Ийнхүү салбарын хөрөнгө оруулаалт хангалтгүй байгаагаас эрдэм шинжилгээний

Хүснэгт 3. Улсын төсвөөс санхүүжүүлсэн судалгаа, хөгжүүлэлтийн ажил

| Судалгааны ажлын төрөл | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|-----------------------------|------------|------------|------------|------------|------------|
| Суурь судалгааны ажил | 160 | 94 | 131 | 94 | 265 |
| Хэрэглээний судалгааны ажил | 159 | 169 | 189 | 215 | 78 |
| Туршилт, хөгжүүлэлтийн ажил | - | 13 | - | - | 10 |
| | 319 | 276 | 320 | 309 | 353 |


Эх сурвалж: БШЯ, 2021



ИННОВАЦ

Инновац нь шинэлэг гэсэн санааг илэрхийлсэн англи үг бөгөөд дэлхийн олон оронд орчуулахгүй хэрэглэж байна. Инновац гэж шинэ болон шинэчилсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, технологийн процессыг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны эцсийн үр дүн гэж тодорхойлсон нь олон тодорхойлтолтоос хамгийн оновчтой нь юм. Товчхондоо энэ ойлголтыг аливаа шинэ бүтээмж, шинэ санааг эдийн засгийн эргэлтэд оруулах гэж хэлж болно.

Инновац бүтээх гурван үндсэн шалтгаан байдаг. Доорх гурван нөхцөл бүрэлдэхэд инновац хөгжих үндсэн суурь бүрдлээ гэж үзэж болно. Гаднын улс орнуудад ч ийм замаар хэрэгжиж байна. Үүнд:



ШИНЭ САНАА,
ШИНЭ
ТЕХНОЛОГИЙГ
АМЬДРАЛД
ХЭРЭГЛЭХ
ХЭРЭГЦЭЭ

1

ШИНЭ САНАА,
ТЕХНОЛОГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ
МЭДЛЭГ, ЧАДВАР
БУХИЙ ХҮН,
ТЕХНОЛОГИ

2

ШИНЭ САНААГ
ОЛОН НИЙТЭД
ХҮРГЭХЭД ҮЗҮҮЛЭХ
ЭДИЙН ЗАСГИЙН
ДЭМЖЛЭГ

3

байгууллагад ашиглагдаж байгаа лабораторийн багаж, техник, тоног төхөөрөмж хуучирч, энэ нь эрдэм шинжилгээний ажлын чанар, өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж, түүний нийгэм, эдийн засгийн үр нөлөө, өгөөжийг бууруулсаар байна.

Иймд олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлэхээр тусгасан.

Энэ хүрээнд эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны үндсэн чиглэлийг шинэчилж, үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, Шинжлэх ухаан, технологийн сангийн зохион байгуулалт, менежментийг сайжруулах, судалгааны лабораториудын менежмент, зохион байгуулалтын эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх зэрэг олон шинэчлэлтийг хийхээр төлөвлөөд байна. Ингэхдээ шинжлэх ухаан, технологийн бүтээлч, цогц үйл ажиллагааг хангах замаар дэлхий ертөнцтэй хөл нийлүүлэн алхаж нано, био, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг тэргүүлэх чиглэлд оруулах хөрөнгө, нөөц болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлж, ногоон, цахим эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн бүс нутгийн жишигт хүргэх зорилт тавьж байна.

Шинжлэх ухаан, инновацын салбарын өөрчлөлт, шинэчлэлт нь төр, хувийн хэвшлийн үр дүнтэй хамтын ажиллагаанаас эхлэх

Нийт олгосон патент

2018
 347

2019
 407


2020
 349

Эх сурвалж: УСХ 2021

ХҮНИЙ ХӨГЖИЛ
**ШИНЖЛЭХ
УХААН,
ИННОВАЦ**

учиртай. Иймд урт хугацааны хөгжлийн бодлогод тус салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэл бий болгож, гадаадын дэвшилтэй технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлэхээр тусгасан. Жишээ нь тоон технологи ашиглан мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чиглэсэн инновацын үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр зорьж байна. Үүний тулд шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын эрх зүйн орчныг шинэчилж, инновацын үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн тусгай зориулалтын сангуйудыг байгуулна. Мөн төрөөс хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын бодлого, татварын таатай орчин бүрдүүлж, хувийн хэвшлийн технологийн хөгжүүлэлтийг дэмжих тогтолцоо, бүтцийг оновчтой болгох хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлнэ. Мөн шинэ мэдлэг бий болгоход гаргасан зардлын тодорхой хэстийг төрөөс нөхөн төлдөг тогтолцоотой болно.

Зураг 23. Шинжлэх ухааны салбарын үзүүлэлт-2020 он



Монгол ухаан - дэлхийн эрдэмтэн
Манай оронд дэлхий дахинд алдар нь түгсэн эрдэмтэн мэргэд олон. Тэдгээр билиг оюун төгөлдөр хүмүүсийнхээ залгамж халааг бэлдэх, цаашдаа улам дэлгэрүүлэхийн тулд амжилт бүтээлийг нь дархлах, алдар сууг нь мөнхжүүлэх үйлсийг дэмжих явдал бол төрийн бодлогын салшгүй хэсэг байх ёстой.




Шинжлэх ухаан, инновацын салбарын бас нэгэн чухал асуудал бол хүний нөөц юм. Тус салбарын хүний нөөцийн хувьд эрдэмтэн судлаачдын хөдөлмөрийн үнэлгээ, үнэлэмж доогуур, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, үйл ажиллагаа хэрэгжихгүй байгаа, дээд боловсрол, шинжлэх ухааны уялдаа холбоо сул, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах механизм бүрэн бүрдээгүй, инновацын зөвлөн дэд бүтэц бий болоогүй зэрэг олон асуудлууд ар араасаа урган гарсан хэвээр байна. Иймд цаашид эрдэмтэн, судлаачдын шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патентад урамшуулалт олгодог тогтолцоо руу шилжих бөгөөд тодорхой зүйлийг хийх шинэ арга замыг гаргасан эсвэл аливаа техникийн шинэ шийдлийг санал болгож буй бүтээгдэхүүн болон арга ажиллагааны (шинэ бүтээл, ашигтай загвар) онцгой эрхийг тэдэнд эзэмшүүлнэ. Мөн судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд суурилсан шагнал, урамшууллын тогтолцоотой болох ба олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог ч бий болгоно.

Лабораториудын нэгдсэн мэдээллийн систем

Лабораториудын нэгдсэн мэдээллийн систем төхөөрөмжийн бүртгэлийг хөтлөн, салбар дундын болон сүлжээ лабораториудад хэрэгжих судалгааны төслүүдийг санхүүжүүлэх, гарсан үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зохицуулалт бий болгоно. Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн суурь санхүүжилтийг шийдвэрлэж үр дүнд суурилсан тогтолцоог нэвтрүүлнэ.

Зураг 24. Лабораторийн нэгдсэн мэдээллийн систем



ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРСОН МЭДЛЭГ



Үндэсний инновацын тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай шинжлэх ухааны парк, инновацын татваргүй бүсийг байгуулж, аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ. Шинэ мэдлэгийг бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэхэд хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, грант олгодог тогтолцоо бий болгоно.



Инновацыг хөрөнгө болгоход дэмжинэ

Бизнес инновац хамгийн чухал. Хэн инновацтай бүтээгдэхүүн санал болгоно, тэр л бусдаас ялгарч өрсөлдөх давуу талыг олж авдаг. Ийм давуу талыг төрөөс дэмжин хөрөнгө оруулах, хөрөнгө оруулагчдад зуучлах, анхны бүтээгдэхүүн гаргахад тэтгэмж олгох зэргээр хөрөнгө босгох, хөрөнгө болгоход дэмжинэ.



ШИНЖЛЭХ УХААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА, ОРОЛЦОО



Тэргүүлэх чиглэлээр судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхэлдэг эрдэм шинжилгээний ажилтны чадвар, бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын үнэлгээний жишигт нийцүүлж, үр дүнд нийцсэн цалин, урамшууллын тогтолцоотой болно. Олон улсын жишигт нийцсэн докторын дараах судалгаа, сургалтыг дэмжин хөгжүүлж, эрдэмтэн, судлаачид олон улсын томоохон судалгаанд оролцох боломжийг нэмэгдүүлнэ. Оюуны өмчийг хараат бус, кодлогдсон технологийн дагуу бүртгэж, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлж, оюуны өмчийн зуучлал, зөвлөх үйлчилгээ, арилжааг хөгжүүлнэ.



Өндөр бүтээмжтэй судалгаа

Докторын дараах судалгааг тусгайлан дэмжих замаар олон улсын түвшин өрсөлдөх, хамтрах, оролцох боломжийг нэмэгдүүлэн өндөр бүтээмжийн үр шимийг хүртэнэ.

ХҮНИЙ ХӨГЖИЛ

ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН

ЗОРИЛТ 2.5. Амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Эрүүл баталгаат орчин
бий болгох үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Амьдралын таатай орчин
бүрдүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Амьдралын хэрэгцээ хангагдсан
орчин бүрдүүлэх үе

Амьдрах орчин гэсэн ойлголтод орон сууцны чанар, гэрэлтүүлэг, агааржуулалт, орон зай мөн түүний бүрэлдэхүүнд орох ногоон байгууламж, зогсоол зэрэг тав тухтай холбоотой үзүүлэлтүүд багтана. Харин эрүүл мэндтэй холбогдох асуудалд агаар, ус, хүнс, дуу чимээ, хог хаягдал, ариутгал зэрэг хүчин зүйлс ордог.

Хүн амьдралынхаа цаг, минут тутмаа хүрээлэн буй орчинтойгоо харилцаа, холбоотой амьдардаг. Тиймээс гадаад болон дотор хүрээлэн буй орчны хүчин зүйлсийн харилцаа хамаарал нь бидний амьдралын чанарт, цаашлаад эрүүл амьдралын хэв маягт нөлөөлж байдаг. Хүнд ээлтэй орчинд хүн төвт архитектурын шилдэг шийдлээр бүтээн байгуулсан, гэр бүлд зориулсан үйлчилгээ ойр орчимд байх, ногоон байгууламжтай, хүүхэд амьдрахад ээлтэй орчин, тоглож наадах аюулгүй талбайтай, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартад нийцсэн: зам харилцаа, орц гарц төвөггүй байх, стандарт шаардлагыг хангасан дэд бүтцийн цогцолборыг ойлгодог.

Монгол Улсын иргэн бүр эх орондоо эрүүл, аятай тухтай амьдарч, ажилтай орлоготой, аюулгүй орчинд, ус агаар, хүнсний аюулгүй байдалд санаа зовохгүй байх нөхцөлийг хангах нь бидний үндсэн зорилтын нэг билээ. Оршин суугаа газар байр байшин, орон гэртээ хүрээлэн байгаа орчны сөрөг нөлөөллөөс ангид байх, дуу чимээ, хог хаягдал, хөрсний бохирдолгүй байх анхан шатны шаардлага хангагдах ёстой. Стандартын ногоон байгууламж, цэцэрлэгт орчныг тэтгэх замаар ногоон бүс, бичил цэцэрлэгт





хүрээлэн байгуулж, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ. Хүнсний хангамж, нийлүүлэлтийн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагаар дамжуулан баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой тогтолцоо бий болгоно.


Дэлхий нийтээрээ хүрэхээр зорьж буй Тогтвортой хөгжлийн зорилгуудын 11 дүгээр зорилго бол “Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих” юм. Энэ хүрээнд 2030 он гэхэд дараах зорилтуудыг биелүүлсэн байхаар зорьж байна. Үүнд:

- Хүрэлцэхүйц, аюулгүй, хямд үнэтэй орон сууц, суурь үйлчилгээгээр хүн бүрийг хангаж, орлого багатай иргэдийн хорооллыг сайжруулах
- Эмзэг бүлгийн хүн ам, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг онцгой анхааран, замын аюулгүй байдал, тухайлбал нийтийн тээврийг өргөжүүлэн сайжруулах замаар аюулгүй, хямд үнэтэй, хүртээмжтэй, тогтвортой тээврийн системийг хүн бүрд хүргэх
- Агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах
- Хүн бүрийг, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр

Хүлцэх ёсгүй асуудал

Бидний өнөөгийн амьдралд тулгарч буй гол бэрхшээл бол агаарын бохирдол гэдгийг энэхүү үзүүлэлтээс харж болно. Үүний сөрөг үр дагавар бидэнд, үр хүүхдэд маань хор уршиг тарьсаар байна. Иймээс уг асуудлыг цаг алдалгүй шийдэх ёстой.

Зураг 25. Агаарын бохирдол ба тав хүртэлх насны 1,000 хүүхдэд ногдох хатгалгаа өвчин, сараар, 2015-2019



ХҮНИЙ ХӨГЖИЛ
**ХҮНД ЭЭЛТЭЙ
АМЬДРАХ
ОРЧИН**



Улаанбаатар хотын агаар дахь нарийн ширхэг тоосонцорын агууламжийн жилийн дундаж Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Агаарын чанарын зөвлөмжид зааснаас даруй

20 дахин

их байна.

настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг аюулгүй, бүх талын оролцоог хангасан, хүртээмжтэй, ногоон болон нийтийн эзэмшилийн талбайгаар хангах

- Хамтын оролцооны, нэгдсэн, тогтвортой хүн амын суурьшлийн төлөвлөлт, менежментийн чадавх, бүх талын оролцоог хангасан, тогтвортой хот байгуулалтыг сайжруулах.

Манай улсын иргэдийн хувьд амьдрах орчны тухайд хурцаар тавигдаж буй асуудлын нэг бол агаарын бохирдол. Улаанбаатар хот агаарын бохирдлоороо дэлхийд дээгүүр бичигдэх болсон. Улаанбаатар хотын агаар дахь нарийн ширхэгт тоосонцор (PM2.5)-ын агууламжийн жилийн дундаж ДЭМБ-ын Агаарын чанарын зөвлөмжид зааснаас даруй 20 дахин их байгаа юм. Энэ нь 5 хүртэлх насны хүүхдийн амьстгалын замын өвчний шалтгаант нас баралтыг 33 хувиар, насанд хүрэгчдийн уушгины архаг бөглөрлийн шалтгаант нас баралтыг 19 хувиар, зүрхний шигдэсийн шалтгаант нас баралтыг 27 хувиар, уушгины хавдрын шалтгаант нас баралтыг 24 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна. Тухайлбал Улаанбаатар хотод 1000 амьд төрөлтөд ногдох төрөлхийн гажигтай төрсөн хүүхэд сүүлийн 5 жилд 5-6 дугаар сард төрсөн хүүхдүүдийн дунд өндөр байжээ. Өөрөөр хэлбэл энэ хугацаанд төрсөн эхчүүдийн жирэмсэлсэн хугацаа 7, 8 дугаар сар бөгөөд ураг эрчимтэй хөгжих үе нь 10 дугаар сараас эхэлж байгаа нь агаарын бохирдол нэмэгдэх хугацаатай давхцаж байна. Мөн Улаанбаатар хотын 1,000 амьд төрөлтөд ногдох өсөлтгүй жирэмслэлт ч агаарын бохирдол хамгийн өндөр байдаг 1-3 дугаар сард их байна. Зүрх судасны тогтолцооны өвчлөл Улаанбаатар хотын хувьд агаарын бохирдол хамгийн өндөр саруудын дараагийн сард өндөр байгаа нь ажиглагдаж байгаа юм.

Үндэсний статистикийн хорооны судалгаанд хамрагдсан өрхийн нийт хүн амын 86.9 хувь ундны усны сайжруулсан эх үүсвэр ашигладаг, 88.8 хувь сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэдэг өрхөд амьдардаг байна.

Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 19 дүгээр зүйлд хүртээмж гэдгийг дараах хэлбэрээр тодорхойлжээ: “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ



авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад, тогторыг илрүүлэх, устахад чиглэсэн эдгээр арга хэмжээг бүх газарт авна” гэж заасан.

Мөн Ази, Номхон далайн орнуудын санаачилгаар бий болсон, манай улсын нэгдэн орсон “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бодитой болгох нь” 2012 оны Инчеоны стратегийн 3 дугаар зорилтод “Биет орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцаа холбоо нь хамруулсан буюу хүртээмжтэй байх нь нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхээ эдлэх урьдчилсан нөхцөл юм” хэмээн заасан байна. Хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй хот, орчныг бий болгох нь зөвхөн тухайн хүн амын бүлэгт ач холбогдолтой төдийгүй нийгмийн бусад бүлгүүд ч энэхүү хүртээмжтэй орчны ашиг тусыг хүртэж байдаг.

Монгол Улс аз жаргалын үзүүлэлт (индекс)-ээр 5.76 оноогоор дэлхийн 149 улсаас 68 дугаарт эрэмблэгдэж байна. Аз жаргалын индексийг амьдралын чанар, ээрэг болон сөрөг сэтгэл хөдлөлийн үзүүлэлтэд тулгуурлан гаргадаг. Амьдралын чанар гэдэг нь өдөр тутам эрүүл, тогтвортой амьдрах суурь хэрэгцээ хангагдсан байдлыг хэлдэг байна. Монгол Улсын ард иргэдийг сайн сайхан амьдралд хөтлөх, ирээдүй хойч үедээ сайн сайхан амьдралаа өвлүүлж

Аз жаргалтай монголчууд

Үндсэн хуульд зааснаар хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй. Амьдрахад таатай орчин хэмээх ойлголт гэдэг нь хүний амьдралын тав тухтай байдлыг бүх талаар хангах гадаад нөхцөл юм. Уг нөхцлийг бүрдүүлснээр монгол хүн бүр аз жаргалтай, нийгэм нь гэрэл гэгээтэй, ирээдүйдээ итгэлтэй, өөдрөг тэнүүн аж төрөх бололцоо бий болно.



ХҮНИЙ ХӨГЖИЛ
**ХҮНД ЭЭЛТЭЙ
АМЬДРАХ
ОРЧИН**



Монгол Улс
аз жаргалын
үзүүлэлтээр

5.76

**ОНОО АВЧ, ДЭЛХИЙД
68 дугаарт
эрэмбэлэгдэж
байна.**

Эх сурвалж: *Country economy, 2022*

үлдээх, шавхагдаж байгаа байгалийн нөөц баялгаа зохицойгоор ашиглах, "тогтвортой сайн сайхан байдал"-ын төлөө хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, ард иргэдийн амьдралын сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарах, байгаль дэлхийн хязгаарлагдмал нөөцөд тулгуурлан хэрэглээний зохицой бүтцийг бий болгох нь чухал.

Иймд эрүүл, баталгаат амьдрах орчныг бий болгох зорилт дэвшүүлсэн бөгөөд энэхүү зорилтын хүрээнд нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэх, агаар орчны бохирдлыг бууруулах цогц хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна уг үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, сайжруулсан түлш, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, нэмэгдсэн өртийн албан татвараас чөлөөлөх, хог хаягдлын цогц менежмент 3R-ийг хэрэгжүүлэх замаар хог, хаягдлыг өдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах загвар, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Түүнчлэн төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжтүй хэрэглэгчийг хэсэгчилсэн бие даасан инженерийн хангамжид холбох, бичил дэд төвүүдийг байгуулах төслийг үе шаттай хэрэгжүүлэх замаар 2050 он гэхэд хот, суурин газарт бүх төрлийн орон сууцыг инженерийн шугам сүлжээтэй болгоно. Мөн орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Ногоон байгууламж, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй аргаар хэрэгжүүлэх буюу саарал ус, сэргээгдэх эрчим хүч ашиглахаар мөн төлөвлөсөн. Ийнхүү амьдрах орчин нөхцөлийг олон улсын стандарт, жишигт нийцүүлэх нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ч бусдаас хамааралгүй, бие даан нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэх юм.

Хүн амын хүнсний нийт хэрэглээний 50 хувийг импортоор оруулж ирдэг улс орныг хүнсний аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй гэж үздэг. Монгол хүний хүнсний хэрэглээнд мах, турилан бүтээгдэхүүн зонхилж, эрдэс амин дэмийн гол эх үүсвэр болдог жимс, жимсгэнэ, нарийн ногоо бага хэвээр байна. Тодруулбал, хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, махан бүтээгдэхүүнээр 97.0 хувь, төмсөөр 100.0 хувь, турилаар 98.3 хувь, хүнсний ногоогоор 60.7 хувийг хангаж байна. Монгол өрх, гэр бүлийн 23 хувьд хүнсний баталгаат байдал ноцтой алдагдаж "өлсгөлөн"-ийн хэмжээнд хүрсэн бол 28 хувьд "дунд зэрэг" гэсэн үнэлэлттэй гарчээ. Үүнээс



Зураг 26. Хүнсний аюулгүй байдлын бүрдэл



Эх сурвалж: ХХААХУЯ, 2022

шалтгаалан хүн амын дундах аминдэм, эрдэс бодисын дутагдал харьцангуй их, хорт хавдрын өвчлөл нэмэгдсэн зэрэг нь Монгол Улс хүн ардынхаа хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоогоо шинэчлэх цаг болсныг харуулж байна.

Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд урт хугацааны хөгжлийн бодлогод хүнсний аюулгүй байдлыг хангах дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд, гений өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдаалах, хадгалах, дамжуулан тээвэрлэхийг хориглоно. Үрийн сан, хөрс хамгаалалт, хөрс боловсруулалт, тариалалт, усалгаа, хураалт, хадгалаалт, тээвэрлэлт, борлуулалт, жижиглэн худалдааг хамарсан төмс, хүнсний ногооны мөшгөлтийн мэдээллийн тогтолцоог бий болгон хүнсний аюулгүй байдлыг бүрэн хянана. Мөн импортын хүнсний бүтээгдэхүүнийг шинжлэх хяналтын лабораторийг байгуулж, чадавхжуулах, бүртгэлийн хяналтыг чангатгах, хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад хургэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Түүнчлэн өрхийн хүнсний баталгаат байдал алдагдахаас зорилтот, эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

БАТАЛГААТ ХҮНС ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙ

Хүний жам ёсны зайлшгүй хэрэгцээ бол хоол хүнс. Энэхүү хэрэгцээгээ органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй баталгаат, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн зүгээс онцгой анхаарах ёстой.

АЯ ТУХТАЙ АМЬДРАЛЫН ОРЧИН



Тохилог амьдралын таатай орчин бүрдүүлэхийн тулд орон сууцны талбайн дундаж хэмжээг нэмэгдүүлэх, түүний чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлэх, хотын суурин газарт ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайг нэмэгдүүлэх замаар цогц арга хэмжээг авч уг зорилтыг хэрэгжүүлэх юм.



Нэгдсэн төлөвлөлттэй орчин

Иргэдийн амьдрах орчныг нэгдсэн төлөвлөлттэй, ногоон байгууламжтай, хүүхдийн тоглоомын орчинтой байлгах шаардлагыг хэвийн хэм хэмжээ болгон мөрдүүлнэ.



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Хүнсний аюулгүй байдлыг мөрдүүлж, хүн ардаа баталгаат хүнсээр хангах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хүнсний сүлжээний бүх шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Цаашид уг тогтолцоог улам боловсронгуй болгож эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт шаардлагын чанарын дээд түвшинд гаргаж, монгол брэндийн эко хүнсийг олон улсад экспортлох нөхцөлийг сайжруулж, хүнсний боловсруулах салбарыг хөгжүүлнэ.



Хүнсний аюулгүй байдал

Хүн ам амьдралынхаа туршид чанартай, шим тэжээллэг, аюулгүй хүнсийг улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, газар зүйн байршилаас үл хамааран тогтвортой, хүртээмжтэй сонгон хэрэглэх боломж бүрдсэн байх ёстой.

ХҮНИЙ ХӨГЖИЛ

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

ЗОРИЛТ 2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Бүтээмжид суурилсан, хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, хүн бүр ажилтай, орлоготой болох орчин, нөхцөлийг бүрдүүлэх үе

ХӨДӨЛМӨРИЙН ЦОНХ ҮЕ

Тухайн улсын тэжээлгэгч насны хүн ам (0-14 болон 65-аас дээш насны) тогтвортой байх эсвэл буурч байхад хөдөлмөрийн насны хүн ам (15-64 насны) өсөж байгаа үеийг хүн ам зүйн “цонх үе” гэж нэрлэдэг. Хүн амын дундаж наслалт нэмэгдэж, төрөлт буурч, хүн амын өсөлт удаашран хөдөлмөрийн насныхын тоо хамгийн их болох үе бидний хувьд 2008 оноос эхэлж 2025-2030 он хүртэл үргэлжлэх төлөвтэй байна.

Дэлхийд 200 орчим сая хүн ажилгүй байгаа нь ажилгүйдлийн түвшин хамгийн өндөрт хүрснийг харуулж байна. Мөн хэдэн зуун сая хүн ажилтай атлаа ядуурлын түвшинд амьдарч байна. Эрчимтэй өрнөж буй мэдээлэл технологийн хурдтай хөгжил, аж үйлдвэрийн IV хувьсгалын өөрчлөлтөд дэлхий дээр 6 сая орчим ажлын байр устаж, 24 сая ажлын байр шинээр бий болж, 800 гаруй сая хүн ажлын байрны өөрчлөлтөөс шалтгаалж шинэ ур чадвар өзэмших шаардлагатай болж байна. Ирээдүйн хөдөлмөрийн тухай 2019 онд гаргасан дэлхийн тайланд хүний чадамж, ур чадварыг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, насан туршдаа суралцах эрхийг хангах, ажлын байранд хөрөнгө оруулалт хийх, зохистой, тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих, хариуцлагаа сайжруулахад анхаарах шаардлага үүсэж байна.

Түүнээс гадна ирэх 15 жилд технологи, хүрээлэн буй орчин, хүн ам зүйн өөрчлөлтөөс үүдэн бидний ажиллаж байгаа арга





барилд ихээхэн өөрчлөлт гарагаар байгаа аж. Монгол Улсын хувьд хөдөлмөрийн зах зээлийн гол мэдээллийн эх үүсвэр болох Ажиллах хүчний судалгаанаас харахад улсын хэмжээнд 15 түүнээс дээш насны нийт хүн амын 1.2 сая нь ажиллах хүч байна.

2010-2021 онд ажиллах хүчний оролцооны түвшин 61.6-56.9 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.5-52.3 хувь, ажилгүйдлийн түвшин 9.9-7.0 хувь байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, уйл ажиллагаа хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтэд эергээр нөлөөлж чадахгүй байгааг харуулж байна.

Өндөр боловсрол өзэмшсэн, мэргэжилтэй ажилгүй иргэдийн тоо нэмэгдсээр байгаа нь хөдөлмөрийн зах зээлд боловсролын түвшин, мэргэжлийн байдлаар эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт харьцааг ихээхэн анхаарах шаардлагатай болсныг харуулж байна. Иймд хөдөлмөр эрхлэх чадвартай, орлого багатай иргэдийг халамжаар бус ажил эрхлэлтээр дэмжихэд чиглэсэн ХАЛАМЖААС-ХӨДӨЛМӨРТ шилжих шинэчлэл хийхээр зорьж байна.

Нийгмийн халамжийн тогтолцооны хувьд өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, эхчүүдэд төрөөс тэтгэвэр, тэтгэмж олгож, тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ хэт өргөн болж жилд дунджаар 800 орчим мянган хүнийг хамруулж, дөрвөн хүн тутмын нэгд төрөөс халамж үзүүлж байгаа нь зорилтот бүлэгт чиглээгүйг харуулж байна.

Монгол Улсын Засгийн газар 72 нэр төрлийн халамжийн хөтөлбөрт жилд 1.7 их наяд /үүнээс 893.5 тэрбум нь цар тахлын нэмэгдэл төсөв/ төгрөг зарцуулж байна. Давхардсан тоогоор нийт 2.3 сая иргэн халамжийн үйлчилгээнд хамрагджээ. Нийгмийн

Ажиллах хүчиний оролцооны түвшин

Ажиллах хүчиний оролцооны түвшин гэдэг нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувь нь ажиллагчид, ажилгүй иргэд байгааг харуулдаг. 2021 оны байдлаар манай улсын нийт хөдөлмөрийн насны хүн амын 56.9 хувь нь ажиллах хүч байна. Харин хөдөлмөрийн насны нийт хүн амын 52.3 хувь нь ажиллагчид байна.

2022 оны I улирлын байдлаар нийт ажиллагдын 48.0 хувь буюу 541.4 мянга нь ажиллах хүч хамгийн их шингээсэн эдийн засгийн 3 салбарт ажиллаж байна. Эдгээр нь хөдөө аж ахуйн салбарт нийт ажиллагчдын 26.6 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 12.0 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 9.4 хувь нь тус тус ажиллаж байна.

Зураг 27. Ажиллах хүчиний бүрэлдэхүүн



ХҮНИЙ ХӨГЖИЛ
**ХӨДӨЛМӨРИЙН
ЗАХ ЗЭЭЛ**



Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйд үнэ цэн нь өсөх мэргэжлүүдээр хүний нөөцөө бэлтгэхэд онцгойлон анхаарч, ажлын байр, мэргэшлийн уян хатан байдлыг дэмжсэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.




халамжийн салбарын зардал ихсэх нь улсын төсөвт дарамт болдог. Түүнчлэн нийгмийн халамжийн хөтөлбөрт удаан хугацаанд хамрагдах нь иргэдийн хөдөлмөр эрхлэх сонирхлыг бууруулах сүл талтай. Тиймээс хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлж, халамжаас хөдөлмөрт шилжих нь чухал юм. Ковид-19 цар тахлаас шалтгаалан дэлхий даяар нийт ажлын байр 114 саяар буурчээ.

Монгол улсын Засгийн газраас дотоодын болон гадаад орчны ажиллах хүчний талбарт гарч буй дээрх өөрчлөлтөөс үүдэн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт хугацааны бодлого, төлөвлөлтийг боловсруулж хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэхийг чухалчилж байна.

Ажилгүйдэл, тэр дундаа залуучуудын ажилгүйдлийг үе шаттай бууруулах, хүн амыг тогтмол орлогын эх үүсвэртэй байлгах зорилгоор ирэх 30 жилд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Нэн тэргүүнд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх замаар хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны статистик мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргах замаар хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого баримтална. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйд үнэ цэнэ нь өсөх мэргэжлээр хүний нөөцийг бэлтгэхэд онцгойлон анхаарч, ажлын байр, мэргэшлийн уян хатан байдлыг дэмжсэн сургалтыг явуулж чадавх, чадамжийн үнэлгээг дээшлүүлнэ. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн онлайн, зайн ажлын

Зураг 28. Ажиллах хүчиний оролцооны түвшин, 2021 он



Эх сурвалж: УСХ, 2022



байрыг нэмэгдүүлэх тогтолцоог хөгжүүлнэ. Бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлж, хүн бүр ажилтай, орлоготой байх орчин, нөхцөлийг бүрдүүлнэ. Үүний тулд цалингийн тогтолцоог шинэчилж гэр бүлийн анхдагч хэрэгцээг цалин, орлогынхаа 50 хувиар хангах боломжийг бий болгоно. Ажлын байр нэмэгдүүлсэн, ажилтнуудынхаа цалин, урамшууллыг нэмэгдүүлэхэд манлайллан ажиллаж байгаа ажил олгогчдыг урамшуулна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

Зураг 29. Халамжаас хөдөлмөрт шилжих шилжилт

Хамтын зүтгэл

Халамжаас хөдөлмөрт шилжих үйл явцын бодлого шийдэл зөв байж, иргэд орлоготой ажлын байртай болно. Гэхдээ түүнийгээ хадгалах, тогтвортой ажиллах нь иргэдээс өөрсдөөс нь ихээхэн шалтгаалах тул хамтын зүтгэл үр дүнд хөтөлнө.



ХАЛАМЖААС



ХӨДӨЛМӨРТ

- Нийгмийн халамж болон **хүн амын өсөлтийг дэмжих** бодлогыг ялгаж, зааглах
- Нийгмийн халамжийн өнөөгийн төсвийн хүрээнд **дахин хуваарилалт хийж** ижил төрлийн хөнгөлөлт, тусlamжийг нэгтгэн үйлчилгээний давхардлыг арилгаж, хамрах хүрээг нь оновчтой, зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- Зорилтот тусlamжийг нэгтгэн үйлчилгээний давхардлыг арилгаж, хамрах хүрээг нь оновчтой, зорилтот бүлэгт чиглүүлэх
- Зорилтот өрх, иргэнийг тодорхойлох арга, аргачлалыг сайжруулах
- Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулах



- Хөдөлмөрийн бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний системийг нэвтрүүлнэ, зайнлас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалтыг бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- Хөдөлмөр эрхлэлтийг **дэмжих төсөл хөтөлбөр**, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн уялдааг хангаж, санхүүгийн шинэ технологи ашиглан **зорилтот бүлэгт дэмжлэгийг** оновчтой хуваарилна.
- Орлого багатай өрхийн ажилгүй гишүүдийг “Үйлчлүүлэгч төвтэй аргачлал” бүхий хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг үйлчилгээнд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- Хөдөлмөрийн **зах зээлийн эрэлтийн судалгаанд үндэслэн** ажиллах хүчин бэлтгэхэд салбарын уялдааг ханган хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- Улсын хэмжээнд **анхны хөдөлмөрийн салбарын** дата портал нэвтрүүлж, нээлттэй **мэдээллийн** сан бүхий цахим хөдөлмөрийн биржийг бий болгоно.

ХҮН БҮР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖ



Хүн амын бүлэг бүрийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлж, цагаар, зайнаас ажиллах уян хатан нөхцөлтэй байдлыг дэмжинэ. Дотоодын нийт бүтээгдэхүүнд цалин болон түүнтэй тэнцэх орлогын эзлэх хувиар шалгуур үзүүлэлт болгон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрэх үр дүng тогтооно. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Зураг 30. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны суурь зарчим, үндсэн эрх



| | | | | | |
|-----------|--------------------------------|-----------|---|-----------|---|
| 01 | үл ялгаварлан гадуурхах; | 02 | дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох; | 03 | хөдөлмөрлөх эрх чөлөөг баталгаажуулах, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах, цалин хөлс авах, амрах; |
| 04 | барьцаа хэрэглэхгүй байх; | 05 | албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох; | 06 | эвлэлдэн нэгдэх, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулах, ажилтан, ажил олгогч, тэдгээрийн төлөөлөгчдийн хоорондын харилцааг зохицуулах эрхийг хангах; |
| 07 | шударга бус үйлдлийг хориглох; | 08 | нийгмийн түншлэлийг хангах; | 09 | хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах; |

Эх сурвалж: УИХ, 2021




ХӨДӨЛМӨРИЙН ЭРЭЛТЭД ШААРДЛАГАТАЙ ХХI ЗУУНЫ ЧАДВАР



Гадаадын хөрөнгө оруулалт болон бусад хэлбэрээр хэрэгжиж буй том төсөл, арга хэмжээнд ханган нийлүүлэлт хийх үйл ажиллагаанд дотоодын аж ахуй нэгжүүдийг бодлогоор татан оролцуулж, нөгөө талаас гаднаас ажиллах, хүч, мэргэжилтэн авах, тэдгээр хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг таатай орчноор ханган шийдвэрлэж, улмаар мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг дотоодын хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

Зураг 31. ХХI зууны ур чадварууд

ХХI ЗУУНЫ УР ЧАДВАРУУД



ХҮНИЙ ХӨГЖИЛ

МОНГОЛ ХҮНИЙ УДМЫН САН

ЗОРИЛТ 2.7. Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээх, дэмжих үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Удмын сангийн аюулгүй байдлыг хангах үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Монгол хүний генийг хамгаалах судалгаанд суурилсан бодлого хэрэгжүүлэх үе

“Удмын сан” гэдэг нь хүн өөрийн гений сангаасаа үр удамдаа дамжуулж буй тодорхой мэдээллийн хувийг хэлдэг. Монгол үндэстний удмын сангаа хадгалж авч үлдэх нь үндэсний аюулгүй байдлын хэмжээнд нөлөөлөх ач холбогдолтой асуудал юм.

Монголын ард түмний бүтээсэн түүх соёлын нэгэн уламжлал бол удам судар, ах дүү, үндэс угсаагаа мэдэх үйл байжээ. Ахан дүүгээ мэдэж таних ёсыг баримтлан журамлан хүндлэх нь ухаант хүний үйлдэн дээдлэх үйлийн нэг бөгөөд монголчууд угийн бичгийг өрхийн түүх болгон хөтөлж, залгамж үедээ өвлүүлэн зааж сурган иржээ. Энэ нь ах дүү, төрөл саднаа мэдэн гал голомт, өмч хөрөнгөө хэндээ уламжлуулах, ах зах, эгч дүүгээ хэрхэн хүндлэх, удам угсаагаа хэвийн цэвэр ариун байлгах олон асуудлыг шийддэг айл өрх бүрд заавал хөтөлдөг нэгэн түүхэн судар болжээ.

Өнөөдөр олон оронд тархаж суурьшсан, дэлхий дээр хамгийн олон хуваагдсан үндэстэн гэвэл Монголыг хэлэх байх. Европод халимаг, зүүн хойд ба төв Азид Буриадууд, Өвөрлөгчид, Шинжаан уйгарын торгууд, Цастьн монгол гэх мэт маш олон хуваагдсан байгаа энэ үед Монголоороо бахархах, Монголын овог удмын хөх толбот гарваль шинжээ хэвээр нь хадгалахыг хаана хаанаа эрхэмлэж ирсэн байна. Өвөг дээдсээс уламжилж ирсэн ёс заншлыг одоо цаг үед хэрэглэх, баяжуулах, зарим нэтийг нь шинэчлэн өөрчлөх, дараа үедээ заах, сургаж өвлүүлэх ёстой.

Угийн бичиг, удмын түүхээ хөтөлж бичсэнээр өөрсдийн өвөг дээдэс, садан төрөл, тэдний ажил үйлс, амьдралын замналыг нь олж





мэддэг. Тэгснээрээ хол, ойрын садан хүмүүс харилцаан туслалцах, ядарснаа өргөн тэтгэх, ах захахаа хүндэтгэх, баяр цэнгэл, уй гашуугаа хуваалцах зэргээр ах дүү, элгэн садны журмыг сахидаг байв. Ураг төрлийн дотроос хэн нэг нь тэrs хэрэг үйлдсэн бол удмын түүхэнд тодорхой тэмдэглэн үлдээдэг байжээ. Иймээс үеийн үед дамжин хадгалагдах удмын түүхэндээ хар толбо үлдээхгүйг хүн бүр хичээж, хэрэв ураг удмын дотроос ийм хүн гарвал "эцэг өвгөдийн ариун нэрийг бузарлав" хэмээн ихэд жигшдэг байсан бөгөөд нөгөө талаар энэ нь хүмүүжлийн асар их ач холбогдлыг өгдөг билээ.

"Алсын хараа-2050" хөгжлийн бодлогод Монгол хүний удмын сангийн үзэл санаа туссан. Энэ нь хүн амаа өсгөх, цус ойртолтоос сэргийлэх бодлого юм. Таван хүүхэдтэй эхчүүдэд эхийн алдрын одон өгдөг байснаа дөрвөн хүүхэдтэй эхчүүдэд өгдөг болгож босгоо намсасан нь хүн амаа олон болгох төрийн бодлогын хэрэгжилт юм. Хүүхдэд мөнгөн тэтгэмж өгч байна. Энэ нь хүн амын өсөлтийг дэмжих төрийн бодлого хэрэгжиж байгаа бас нэг хэлбэр. Монголын залуу гэр бүлийн нийгмийн өмнө хүлээсэн нэг том чухал журамт үүрэг бол нөхөн үржихүйн үүрэг хариуцлага юм. Нөхөн үржихүй бол эхнэр, нөхөр өөрсдийгөө орлох тооны хүүхэдтэй байхаас гадна нэмээд тодорхой тооны хүүхэдтэй байх явдал юм. Өөрөөр хэлбэл гурав ба дөрөв, түүнээс олон хүүхэдтэй байж нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлнэ. Монголчууд турван хүүхдийг "төгс", дөрөв буюу түүнээс дээш хүүхдийг "төгс төгөлдөр" хэмээн ярьж иржээ. Энэ нь үр хүүхдийн талаар баримталж ирсэн зан суртахууны сайхан уламжлал юм.

Үүнээс үүдэн өнөөдөр нөхөн үржихүйн үүрэг хариуцлага, овог удмаа цэвэр ариун байлгах хүсэл эрмэлзэл, угийн бичиг, удмын түүхээ зөв хөтлөх арга зүйг хамгийн түрүүнд анхаарах ёстой. Залуу хос хоёр талынхaa аав, ээж, өвөг эцэг, эмэг эхээс асуугаад элэнц, хуланцынхaa тухай үнэн зөв мэдээллийг цуглувулж, өөрсдийн намтар түүхээр баяжуулан, дараа үедээ үлдээж хэвшигүүлэх нь чухал юм. Үүний үр дүнд яваандаа есөн үе дотроо бие биеэ сайн мэддэг овог, удам бий болох бөгөөд нөгөө талаар овог, удмаа ингэж хадгалж явахад монголчуудын тэр сайхан уламжлалт ёс заншил үе дамжиж өвлөгдөнө. Тухайлбал цагаан сар, ургийн баярыг дурдаж болно. Цагаан сараар ахмад настай хүмүүстэй золгож хүндэтгэл үзүүлснээр залуу үе нь удам угсаагаа мэдэх, тэднийг тойрч бие биеэ мэдэлцэх нь чухал зүйл юм. Үүнтэй адилаар сүүлийн үед ургийн баяр цугларалтыг хийдэг уламжлал тогтоод байна. Ингэж хаана хаанаа сайн анхаарч байгаагийн үр дүнд угийн бичиг, удмын түүхээ хөтлөх нь түгэн дэлгэрч тухайн овог удам, тэдгээрийн залуу гэр бүлд үзүүлэх нөлөө сургамж арвижих юм.

“

Монголчууд бид
өөрсдийн удмын санг
хамгаалах тухайд
эртний уламжлалтай ард
түмэн. Тэрхүү хэсэг зуур
маргагдсан уламжлалыг
орчин үеийн шинжлэх
ухааны ололт амжилтад
тулгуурлан шинээр
сэргээн сануулж, үеэс үед
тасралтгүй өвлүүлэх нь
чухал.

”



Манай орон өргөн уудам нутагтай ч, цөөн хүн амтай улс. Бидэнд улам олуулаа болох хэрэгцээ шаардлага маш их. Ингэхдээ зөвхөн тоон үзүүлэлтээр биш, үр хойчоо эрүүл саруул өсгөж бойжуулах, аливаа удамшлын өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд төрийн бодлого чиглэгдэх учиртай.



Угийн бичиг нь түүх соёлын ач холбогдолтойн зэрэгцээгээр удмын эрүүл мэндийн байдлыг мэдэх толь юм. Бие хүн үхэж үгүй болох авч хүний удмыг дамжуулан авч явдаг ген хэмээх гайхамшигт өртөнц ер мөхдөггүй мөнх ажээ. Өчүүхэн жишээ хэлэхэд таны нүдний өнгө, царай зүс, зан төрх, явдал суудал, оюун ухаан зэргийг хадгалан дамжуулах ген хэдэн зуун жилийн өмнөх өндөр өвөг, эмгээс эхлэн бөлөнцөр сунжрах хүртэл өөрчлөгдөхгүй хадгалагдан байдаг. Ген устаж үгүй болохгүй, шинээр үүсэхгүй. Гений өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд хор учирч, удамшин дамжих өвчин үүснэ. Гений өөрчлөлт, гэмтэл соготой холбогдон үр удамд дамжих эмгэгийг удамшлын өвчин гэдэг. Удамшлын өвчинөөс сэргийлэх, удмыг хэвийн цэвэр ариун байлгахад хүн бүрийн эрхэмлэх хэдэн зүйл бий. Үүнд:

- Яс, угсаа, удам судар, ах дүү наараа сайн мэдэж, угийн бичиг хөтлөх
- Ах дүү, төрөл төрөгсдийн хооронд гэр бүл үүсэж, цусан төрлийн холбоо бий болохоос сэргийлэх
- Гений шинж чадвар, хэвийн байдалд муу нөлөөлөх хорт зуршилд автхааас болгоомжлох (архи, тамхи, мансууруулах эм, химийн бодис, цацрагийн нөлөө)

Хувь хүний гений сан нэн баялаг, хичнээн олон үр удам төрүүлнэ төдий чинээ түүний үрийн санд үүсдэг гений олон хувилбар хоршууд үр удмууддаа аль болох бүрэн дамжих боломж нээгддэг. Хүн бүр өөрийн гений сангийн тодорхой хувийг л үр удмууддаа дамжуулдаг. Гений сангаас дамжиж буй тэр тодорхой хувийг "удмын сан" хэмээн нэрлэх нь зүйд нийцэх юм. Ийм учраас манай монголчууд тухайн үе удмын гений сангаас дараачийн үе удамд удамшин дамжиж буй тодорхой хэсгийг "удмын сан" хэмээн нэрлэн заншиж байна

1997 оны нэгдүгээр сарын 8-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 17 дугаар тогтоол батлагдсанаар удмын овгийг хэрэглэх болсон. Харин 2007 онд Засгийн газар 257 дугаар тогтоолоор угийн бичиг хөтлөх журмыг баталсан. Иргэд удам угсаагаа мэдэхгүйгээс болж гэр бүл болох тохиолдол цөөнгүй гарч байна. Хувь хүний гений сан нэн баялаг, хэчнээн олон үр удам төрүүлнэ төдий чинээ түүний үрийн санд үүсдэг гений олон хувилбар, хоршууд үр удмууддаа аль болох бүрэн дамжих боломж нээгддэг. Монголчууд тухайн үе удмын гений сангаас дараагийн үе удамд удамшин дамжиж буй тодорхой хэсгийг "удмын сан" хэмээн нэрлэн заншиж байна. Хувь хүний эцэг эхийн гений сангаасаа өвлөн авсан удмын сан бол түүний оюун ухаан, бие бялдрын хөгжил, өвчин эсэргүүцэх, урт наслах чадвар, байгаль, нийгмийн юмс үзэгдлийн мөн чанарыг танин ойлгох, өөрийн авьяас билиг, чадвараа нээн илрүүлж насан туршийн амьдралаа тэтгэх, улс



Зураг 32. Чингис хааны алтан ургийн угийн мод.



Эх сурвалж: Ийгл ньюс телевиз, 2017

үндэстнийхээ хөгжилд өөрийн гэсэн хувь нэмэр оруулах хөрс нь болдог аж.

Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийллэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжих үүднээс хөгжлийн баримт бичигт удмын санг бие даасан зорилт болгон оруулжээ. Ингэхдээ угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээх, удмын сангийн аюулгүй байдлыг хангах, мөн судалгаанд суурилсан генийг хамгаалах бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Түүнчлэн уdamшлын өвчнийг эрт илрүүлэн, оношлох чадавхыг хөгжүүлэхээр зорьж байна.

Хүн ам цөөн, тархай бутархай
оршин суудаг, нүүдлийн
онцлогтой амьдралын
хэв маяг нь бидэнд угийн
бичгийн хөтлөлтийн
ач холбогдлыг үргэлж
сануулсаар ирсэн. Өвөг
дээдсээс уламжлан ирсэн
энэ заншил улам бүр чухал
болсоор байна

УГИЙН БИЧИГ

Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх уламжлалыг сэргээн хөгжүүлж, угийн бичиг хөтлөх, цус ойртолтыг багасгах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ. Гадаадын иргэн, харьялалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.



Угийн бичгийн учир

Монголын ард түмний бүтээсэн түүх соёлын нэгэн уламжлал бол удам судар, ах дүү, үндэс угсаагаа мэдэж таних ёсыг баримтлан журамлан хүндлэх нь ухаант хүний үйлдэн дээдлэх үйл юм.



УРГИЙН БАЯР



Монголчууд эрт дээр цагаас ураг холбох ёсыг машид эрхэмлэж, ургаа сонгох, удмаа таниулах, ургийн баяр хийх, угийн бичиг хөтлөх уламжлалт соёл, ёс заншлыг бий болгожээ. Гэр бүлийн амьдрал үүсэх, ханилах, соёлыг бүр ураг, удмын түвшинд ойлгож ухаарч ирсэн нь танин мэдэхүй, нийгмийн соёлын чухал ач холбогдолтой. Монголчууд их төлөв есөн үеэ хүртэл төрөлсдөг бөгөөд есөн үе өнгөрмөгц яс хагалахуй хэмээх ёслол үйлдэн, түүнээс хойш төрөл сунжирсан гэж үзэж хоорондоо ураг холбохыг зөвшөөрдөг байна.



Баяр цэнгэл

Ургийн баяр бол хол, ойрын садан хүмүүс харилцан туслалцах, ядарснаа өргөн тэтгэх, ах захаа хүндэтгэх баяр юм. Ах дүү, төрөл саднаа мэдэн гал голомт, өмч хөрөнгөө хэндээ уламжлуулах, ах зах, эгч дүүгээ хэрхэн хүндлэх, уdam угсаагаа хэвийн цэвэр ариун байлгах сайхан ёс билээ.

ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Их Хурал. (2021.). Хөдөлмөрийн тухай хууль.

Монгол Улсын Засгийн газар. (2021). "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн танилцуулга. УБ.

Боловсрол, Шинжлэх Ухааны Яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Үндэсний Статистикийн Хороо. (2022) "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод сууринлас боловсролын хэтийн тооцоо 2020-2050 он. УБ.

Дэлхийн банк. (2022). Дундаж наслалтын үзүүлэлт. The World Bank: https://data.worldbank.org/indicator/SP.DYN.LE00.IN?end=2020&name_desc=true&start=1960&view=chart

Дэлхийн банк. (2022). Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулж буй зардлын ДНБ-д эзлэх хувь.

The World Bank: https://data.worldbank.org/topic/science-and-technology?name_desc=true

Ийгл ньюс телевиз. (2017). Чингис хааны алтан ургийн мод. eagle.mn: <http://eagle.mn/r/23197>

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. (2022). Хүний хөгжлийн илтгэл, УБ. Хүний хөгжлийн тайлан: <https://hdr.undp.org/data-center/human-development-index#/indicies/HDI>

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://1212.mn/>

Үндэсний Статистикийн хороо. (2022). Боловсролын салбарын хэтийн тооцоо. УБ.

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Хүн амын нас барагтын зонхилох шалтгаан. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2100_011V1

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Нийт олгосон патент. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2002_054V2

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний тоо. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_019V1

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Гэр бүл цуцалтын тоо. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_018V1

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Агаар дахь бохирдуулагч бодисын агууламж. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0400_018V1

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Гадаад харилцааны яам. Статистик мэдээллийн нэгдсэн сан: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2400_015V2

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам. (2019). Салбарын танилцуулга. УБ.

Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Эрүүл Мэндийн Яам. (2020). Салбарын танилцуулга. УБ. <https://countryeconomy.com/>. (2022). world happiness index. <https://countryeconomy.com/demography/world-happiness-index/mongolia>

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

| | | | |
|-------|---------------------------------------|--------|---|
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс | УИХ | Улсын Их Хурал |
| АШУИС | Анагаахын шинжлэх ухааны их сургууль | ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| БШУЯ | Боловсрол, Шинжлэх ухааны яам | ХААИС | Хөдөө аж ахуйн их сургууль |
| ГХЯ | Гадаад харилцааны яам | ХБӨ | Халдварт бус өвчин |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн | ХНХЯ | Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага | ШУТИС | Шинжлэх ухаан, Технологийн их сургууль |
| МУИС | Монгол Улсын Их сургууль | ЮНЕСКО | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага |
| МУБИС | Монгол Улсын Боловсролын их сургууль | ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| МХХТ | Мэдээлэл харилцаа, холбооны технологи | | |
| НҮБ | Нэгдсэн Үндэстний Байгууллага | | |